НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН
2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/Д | ДЭД САЛБАР | ЗОРИЛТ | АРГА ХЭМЖЭЭ | ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Орон зайн оновчтой төлөвлөлт | 16 | 60 | 89.0% |
| 2 | Хуулиар хүлээх чиг үүрэг | 11 | 75 | 98,0% |
| 3 | Дүрмээр хүлээх чиг үүрэг | 1 | 7 | 100.0% |
| **НИЙТ** | | **28** | **142** | **94.3%** |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***ЗОРИЛГО 1. ОРОН ЗАЙН ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:*** | | | | | | | |
| *НЗДҮАХ-ийн 6.1. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологи нэвтрүүлнэ.* | | | | | | | |
| Зорилт 1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна. (*НХТЖҮЧ-ийн 9.1.1, НЗДҮАХ-ийн 6.1.1, ХАХТ-ний 6.1.1.1, НХЖТ-ний 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.5, 5.1.6, НСТ-ний 6.1, ХБХГ-ын СТ-ний 6.1.1)* | | | | | | | |
| 1.1.1 | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулна. | - | УИХ-аар батлагдсан баримт бичгийн тоо | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал концепц батлагдсан. | 1 | Засгийн газрын хуралдаанаар "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г хэлэлцүүлэн Улсын Их хуралд өргөн барих ажлын хүрээнд Сангийн яамнаас 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хөрөнгө оруулалтын тооцоо засварлах санал ирүүлсэн. Тус саналын дагуу хөрөнгө оруулалтын тооцоог засварлаж, Барилга, хот байгуулалтын яаманд 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 01/02/378 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>2023 оны 04 дүгээр сард Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг сүүлийн 3 жилд хийгдсэн томоохон төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан тусгаж нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, алсын хараатай нийцүүлж төлөвлөлтийг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 35 дугаар хурлаар хэлэлцүүлж гарсан шийдвэрийн дагуу "Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний зөвлөх үйлчилгээний ажлын удирдамж, даалгавар боловсруулах ажлын даалгавар боловсруулан үүрэг даалгаврын дагуу ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Барилга, хот байгуулалтын Сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 94/А/443 дүгээр тушаал, | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, ажлын хэсгээс "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний баримт бичигт "Сонсголонт хот", "Сэлбэ сэргэлт" төслийг уялдуулан, баяжилт хийж дахин боловсруулах үүрэг даалгавар өгсөн. Үүрэг даалгаврын дагуу боловсруулалт хийгдэж байна. | |
| 1.1.2 | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулна. | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал концепц батлагдсан. | 1 | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдана. | 0 |
| 1.1.3 | Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийг боловсруулна. | 350,0 | Боловсруулсан баримт бичгийн тоо | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө | 1 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/113 дугаар захирамжаар Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг 2022 онд 3 удаа хуралдаж, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албатай хамтран эрдэмтэн судлаачидтай уулзалт зохион байгуулж газрын төлбөрийн бүсчлэлийн талаар мэдээлэл солилцон ажилласан. Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хурлаар Нийслэлийн тэг гортиг бүхий эдэлбэр газрын бүсчлэл тогтоох шалгуур үзүүлэлт, эдэлбэр газрын бүсчлэл, бүсчлэлийн дүрмийн төслийг боловсруулах ажлын талаар Нийслэлийн Ерөнхий архитектор танилцуулга хийж, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепци/-тай уялдуулан боловсруулахаар хойшлуулав.<br>"Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлуулсны дараа хийгдэх ажил тул хугацаа болоогүй. | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.4 | Нийслэлийн ногоон бүс /зуслан/-ийн 22 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулна. | 592,3 | Боловсруулсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тоо | 4 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө | 22 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/74 дүгээр захирамжаар Нийслэлийн ногоон бүс /зуслан/-ийн 22 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажилд захиалагчийн хяналт тавих эрхийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд шилжүүлсэнтэй холбогдуулан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын үе шатны тайлан, мэдээлэл болон зуслантай холбоотой иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг актаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2023 оны 01/02481 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| 1.1.5 | Хот төлөвлөлтийн норм, дүрэмд заасан хүн ам, барилгажилтын нягтрал хэтэрсэн хэсгийн судалгааг боловсруулж, барилгажилтын нягтралыг хориглох бүсийг шинэчлэн тогтооно. | - | НИТХ-ийн тогтоол | 2018 онд 111 байршлын 1044 га талбайд хүн амын нягтралыг хориглох шийдвэр гарсан. | 1 | Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНбД 30.01.04-т заасан хүн амын тооцоот нягтрал 1 га газарт 460 хүн байх хязгаарыг давсан 6 дүүргийн 111 хэсгийн 1163 га газрын нягтралын судалгааг гаргаж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 19 дүгээр хурлаар хэлэлцүүлсэн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНбД 30.01.04-д заасан хүн амын тооцоот нягтралын хязгаарыг давсан байршлуудыг баталсан. | 100 |
| 1.1.6 | Гэр хорооллыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулна. | 300,0 | Батлагдсан стратеги төлөвлөгөөний тоо | - | 1 | Улс, нийслэлийн 2022, 2023 оны төсөвт тусгуулахаар саналаа албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй. Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгуулахаар саналаа 2023 оны 01/01/1324 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 30 |
| **Зорилт 2. Төр захиргаа, мэдээлэл технологи, бизнес санхүү, соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, олон нийтийн төвүүдийг байгуулж, хотын хэт төвлөрлийг бууруулна.** ***(НЗДҮАХ-ийн 6.1.2, ХАХТ-ний 6.1.2.1, НХТЖҮЧ-ийн 9.2.1. НХЖТ-ний 5.1.7, ХБХГ-ын СТ-ний 6.1.2)*** | | | | | | | |
| 1.2.1 | “Нисэх, Яармаг” хотын шинэ төвийн ерөнхий төлөвлөгөөг /Нисэх, | - | Шинэчлэн боловсруулсан ХЕТ-ний тоо | Суурь судалгаа хийгдсэн. | 1 | Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/893 дугаар захирамжаар “Яармаг” хотын шинэ төв | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол/ шинэчлэн боловсруулж, төлөвлөлтийн дагуу бүтээн байгуулалт хэрэгжих боломжийг бүрдүүлнэ. | | | | | буюу 27 дугаар нэгж хорооллын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулахыг Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Хот байгуулалт, хөгжлийн газарт тус тус даалгасан. Ажлын гэрээ 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 2023/А/893/01 дугаартай батлагдсан. Тус гэрээнд тусгагдсаны дагуу дундын тайланг хүлээн авч, Мэргэжлийн зөвлөлийн 39 дүгээр хурлаар хэлэлцүүлэн гарсан үүрэг даалгаврын дагуу гүйцэтгэлийг боловсруулахад хяналт тавьж ажиллаж байна. | |
| 1.2.2 | Сэлбэ дэд төвөөс Чингэлтэй дүүргийн 14,18 дугаар хороо руу инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ татах ажлын зураг төсөл батлуулна. | 109.1 | Батлуулсан баримт бичгийн тоо | Эцсийн тайлан хүлээн авсан | 1 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1234 дүгээр захирамжийн дагуу "Сэлбэ дэд төвөөс Чингэлтэй дүүргийн 14,18 дугаар хороо руу инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ татах ажлын зураг төсөл боловсруулах" Зөвлөх үйлчилгээний гэрээг "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-тай байгуулан Захиалагчийн хяналт тавин ажиллав. Тус ажлын эхлэлийн, дундын, эцсийн тайланг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Барилгажилтын төсөл 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан. | 100 |
| 1.2.3 | Эмээлтийн эко аж үйлдвэрийн паркийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлуулна. | 30.0 | Батлуулсан баримт бичгийн тоо | Эцсийн тайлан хүлээн авсан | 1 | Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, эдийн засгийн өрсөлдөх чадвар, ажлын байрыг нэмэгдүүлэх, экспортын чиг баримжаатай бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилготой "Эмээлт эко аж үйлдвэрийн парк"-ийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар ээлжит бус хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан. | 100 |
| 1.2.4 | Сонсголон, Амгалан, Шинэ төв дэд төвийн ТЭЗҮ, ерөнхий төлөвлөгөө, | 425.0 | Батлуулсан баримт бичгийн тоо | Эцсийн тайлан хүлээн авсан | 3 | Сонсголон, Амгалан, Шинэ төв дэд төвийн ТЭЗҮ, ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл боловсруулах ажлын дундын болон эцсийн | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | барилгажилтын төсөл батлуулна. | | | | | тайланд хяналт тавин гадна шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг зөвшилцсөн. Магадлалын дүгнэлтийг баталгаажуулан 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдөр хүлээн авсан. | |
| 1.2.5 | Нисэх, Тахилт, Дарь эх, Монель, Бичил, Ургах наран Хайлааст олон нийтийн төвүүдийн ТЭЗҮ, барилгажилтын төсөл батлуулна. | 619.7 | Батлуулсан баримт бичгийн тоо | Эцсийн тайлан хүлээн авсан | 7 | Нисэх, Тахилт, Дарь эх, Монель, Бичил, Ургах наран, Хайлааст олон нийтийн төвүүдийн ТЭЗҮ, барилгажилтын төсөл боловсруулах ажлын дундын болон эцсийн тайланд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд гадна шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэлд санал хүргүүлж, төлөвлөлтийн шийдэл зөвшилцсөн. Барилга, хот байгуулалтын яамны харьяа Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар Дарь-Эх, Монель, Тахилт олон нийтийн төвүүдийг хэлэлцүүлэх 2023 оны 01/02/2957 дугаартай албан бичиг хүргүүлсэн. | 90 |
| Зорилт 3. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн иргэд, олон нийтэд нээлттэй болгон, тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ. *(НЗДҮАХ-ийн 6.1.3, ХАХТ-ний 6.1.3.1, НХТЖҮЧ-ийн 9.3, НХЖТ-ний 5.1.12, 5.1.13. НСТ-ний 6.1, ХБХГ-ын СТ-ний 6.1.1)* | | | | | | | |
| 1.3.1 | Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгоно. | 112.5 | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 80 | 100 | - Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/923, 2023 оны А/73 дугаар захирамжийн дагуу Смартдата ХХК-тай байгуулсан НХААГ/202212160, НХААГ/202212160-1 дугаартай гэрээнд захиалагчийн хяналт тавин ажиллаж, эцсийн тайланг Захиргааны зөвлөлийн 2023 оны 04 дүгээр хурлаар хэлэлцүүлэн, (сервер, тоног төхөөрөмж, eBarilga геопортал, гар утасны аппликэйшний эх файл, дотоод удирдлагын системийн гарын авлага) хүлээн авсан. Хот байгуулалт, хөгжлийн газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Хөрөнгө бүртгэлд авах тухай” А/13 дугаар тушаалаар бүртгэлд авсан. | 100 |
| 1.3.2 | Нийслэлийн хаягийн мэдээллийн санг шинэчлэн “Улсын хаягийн нэгдсэн систем”-д бүрэн холбоно. | 100.4 | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 50 | 100 | Тус ажлын дундын тайланг Захиргааны зөвлөлийн 2023 оны 04 дүгээр хурлаар, эцсийн тайланг Захиргааны зөвлөлийн 2023 оны 08 дугаар хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд хаяг олгох, төлөвлөх дэд программ хангамж, байр зүйн зургийн хөрвүүлэлтийн ажлуудыг засварлах, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дахин нягтлан шалгах ажлыг хийж гүйцэтгэж ирүүлэхээр шийдвэрлэн 2023 оны 05/1588 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Үүний дагуу 7 удаагийн цахим уулзалтыг хийж, өдөр тутамд харилцан, хамтран ажиллаж сайжруулалтыг хийж гүйцэтгэн эцсийн тайланг Захиргааны зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсан. | |
| Зорилт 4. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, газрыг дахин зохион байгуулах төслийг үргэлжлүүлэн, инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангах ажлыг эрчимжүүлнэ. *(НЗДҮАХ-ийн 6.1.7, НХЖТ-ний 5.1.25, НСТ-ний 6.1)* | | | | | | | |
| 1.4.1 | Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, боловсруулна. | 23,713.8 | Ажлын зургийн тоо | Ажлын зургийн даалгавар 9 , байршилд 45 баталсан. | 45 | - Гэр хорооллын дахин төлөвлөлтийн 12 байршилд гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл зөвшилцсөн.<br>- Гэр хорооллын дахин төлөвлөлтийн **14** байршилд дулаан хангамжийн техникийн нөхцөл, 8 байршилд цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг шийдвэрлэсэн.<br>- Гэр хорооллын дахин төлөвлөлтийн гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг 13 байршилд зөвшилцсөн.<br>- Гэр хорооллын дахин төлөвлөлтийн гадна инженерийн шугам сүлжээний 3 байршилд барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд ажилласан. Үүнд:<br>✓ Сүхбаатар дүүрэг 11-р хороо. Пример инвестмент ХХК-ийн ус дулаан хуваарилах төв, гадна инженерийн шугам сүлжээ,<br>✓ Баянзүрх дүүргийн 12 дугээр хороо, Бат-хэрэйд ХХК-ийн дулаан хуваарилах төв, гадна инженерийн шугам сүлжээ,<br>✓ Баянгол дүүргийн 2 дугаар хороо. 27 дугаар байр, Грейт роуд ХХК-ийн гадна инженерийн шугам сүлжээ | 70 |
| 1.4.2 | Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн | - | Үйл ажиллагааны | 2 | 4 | Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн хүрээнд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх дэд бүтцийн төв буюу | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүрээнд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх дэд бүтцийн төв буюу “Сервис центр”-ийн үйл ажиллагааг жигдрүүлнэ. | | хэрэгжилт, хувь | | | “Сервис центр”, сервис центрт холбогдох 200 орчим айл өрхийн гадна дулаан хангамж, гадна ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зураг төслийг 3 байршилд зөвшилцсөн. Үүнд:<br>✓ Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо,<br>✓ Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хороо,<br>✓ БЗД-ийн 19 дүгээр хороо. | |
| 1.4.3 | Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн ажлыг үргэлжлүүлнэ. | 98.9 | Төслийн байршлын тоо | 1 | 2 | - Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд Баянзүрх дүүргийн Улиастайд 1 байршилд саналаа албан бичгээр хүргүүлсэн.<br>- Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийг барилгажуулах төслийн инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний ажлын даалгавар батлагдсан. | 100 |
| 1.4.4 | Захын бүсийн гэр хороололд бие даасан эх үүсвэр /сэргээгдэх эрчим хүч, цахилгаан, шингэрүүлсэн болон хийн түлш/ бүхий технологийг нэвтрүүлэх санал боловсруулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | - Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээтэй хосолмол ажиллагаатай шингэрүүлсэн шатдаг хийн технологи бүхий дулааны станц төлөвлөгдсөн. Үүнд:<br>✓ Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо,<br>✓ Хан-уул дүүргийн 6 дугаар хороо.<br>Тус төлөвлөж буй дулааны эх үүсвэрийн бүтээн байгуулалтын ажил хийгдсэнээр төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд өвлийн Оргил ачааллын үед дулаан хангамжийн нэгдсэн сүлжээнд холбогдох боломж бүрдэнэ.<br>- Нийслэлийн 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд төлөвлөж буй 80Гкал/цаг-ийн хийн технологи бүхий эх үүсвэр, Хан-Уул дүүргийн 6 дугаар хороо, Яармагийн гэр хорооллын бүсэд 80Гкал/цаг-ийн хүчин чадалтай хийн технологийн дулааны эх үүсвэрийн газар олголтын асуудлыг тусгуулахаар саналаа Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.<br>- Улаанбаатар хотод сэргээгдэх эрчим хүч ашиглаж ахуйн цахилгаан хэрэглээгээ хангаж | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мөн илүүдэл үйлдвэрлэсэн эрчим хүчээ түгээх сүлжээнд нийлүүлж байгаа **24** хэрэглэгч байна.<br>- Захын бүсийн гэр хороололд бие даасан эх үүсвэр /сэргээгдэх эрчим хүч, цахилгаан, болон хийн түлш/ ашиглах технологи болон байршлыг судалж байна. | |
| Зорилт 5. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулна.(*/НХТЖҮЧ-ийн 9.8.1, НЗДҮАХ-ийн 6.1.9, НХЖТ-ний 5.1.38, 5.1.39. НСТ-ний 6.1, ХБХГ-ын СТ-ний 6.1.9)* | | | | | | | |
| 1.5.1 | Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зургийн даалгаврыг боловсруулан баталж, төлөвлөлтийн шийдэл, ажлын зураг төсөлд хяналт тавьж, зөвшилцөж ажиллана. | 15,132.0 | Ажлын зураг төсөл зөвшилцсөн тоо | 18 багц байршилд гадна инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний угсралт хийгдсэн | 26 | - Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийн хүрээнд нийт 11 байршилд шаардлагатай 26,707.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын өртгийг шийдвэрлүүлэхээр 2022 оны төсвийн тодотгол, 2024 оны төсөвт саналаа албан бичгээр хүргүүлсэн.<br>- Ажлын зураг төслийн даалгавар 3 байршилд батлуулсан.<br>- Ажлын зураг төслийг 4 байршилд зөвшилцсөн.<br>- Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл өөрчлөх, ажлын зураг төслийн холболтын цэгийг өөрчлөх зэрэг асуудлаар хангагч байгууллага, төсөл хэрэгжүүлэгчтэй уулзалт зохион байгуулан 4 байршилд шийдэл гаргасан.<br>- Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын гадна дулаан хангамжийн техникийн нөхцөлийн 10 байршлыг шийдвэрлүүлсэн.<br>- Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын гадна шугам сүлжээний 3 байршилд барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллав. Үүнд:<br>✓ Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хороо. 51,52 дугаар цагаан байруудыг буулган дахин | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | барилгажуулах төслийн дулаан хуваарилах төв, гадна шугам сүлжээ,<br>✓ Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо. Пример инвестмент ХХК-ийн дулаан хуваарилах төв, гадна дулааны шугам сүлжээ,<br>✓ Баянгол дүүргийн 2 дугаар хороо, 27 дугаар байр, Грейт роуд ХХК-ийн гадна инженерийн шугам сүлжээ.<br>- Төсөл хэрэгжүүлж байгаа 3 байршлын шугам сүлжээний холболтын цэгийн асуудлыг шийдвэрлэхэд хангагч байгууллагатай зөвшилцөж хамтран ажиллаж байна. Үүнд:<br>✓ СХД-ийн 5 хороо Таван шар орчмын барилгажилтын төсөл,<br>✓ Нэхмэлийн шарын барилгажилтын төслийн гадна цэвэр, бохир усны шугамын ажил,<br>✓ СБД-ийн 6 хороо Уран проект ХХК-ийн гүйцэтгэж байгаа төслийн гадна бохир усны шугамын ажил<br>Тус шугамын бүтээн байгуулалтын ажил хийгдсэнээр 2172 айлын орон сууцны барилгын эхний ээлжийн 117 өрхийн орон сууцны барилга ашиглалтад орох боломж бүрдэнэ.<br>- 1 байршилд гадна дулаан хангамжийн ажлын зураг төсөл зөвшилцсөн. | |
| 1.5.2 | Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын судалгаа, загвар зураг төслийг боловсруулна. | - | Боловсруулсан загвар зураг | - | 1 | 2023 онд 3 байршилд загвар зураг баталсан. Үүнд:<br>✓ Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 21, 22 дугаар байрыг буулган, шинээр барих “Уран проект” ХХК-ийн загвар зураг,<br>✓ Баянгол дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны дав-7, дав-8, дав-11, дав-12 | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар байрыг буулган шинээр барих "Тэргүүн чансаа" ХХК-ийн загвар зураг,<br>✓ Баянгол дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 26, 27 дугаар байрыг буулган шинээр барих "Грэйт роуд" ХХК-ийн загвар зураг.<br>Улс, нийслэлийн төсөвт хөрөнгө оруулалтын санал хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй. | |
| 1.5.3 | Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг хүчитгэх, дахин барилгажуулах, газар чөлөөлтөд хамруулах төлөвлөгөөнд санал өгнө. | - | Саналын тоо | - | 1 | - Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд газар зохион байгуулалтын 2023 оны тодотголд тусгуулах 81 байршлын саналыг 2023 оны 3/529 дугаартай албан бичгээр хүргүүлэв.<br>- Нийслэлийн 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчтэй байршлын мэдээллийг хүргүүлэв.<br>- Иргэн, төрийн захиргааны байгууллагаас ирсэн дахин төлөвлөлтөд хамрагдах хүсэлтийн дагуу газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээ хийх шаардлагатай барилгын судалгааг гаргав. | 100 |
| **Зорилт 6. Барилга байгууламжийг паспортжуулан, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийж, хүчитгэлийн зураг боловсруулж, лаборатори байгуулна.** (*ЗГҮАХ-ийн 3.7.3, НХТЖҮЧ-ийн 9.9.1, НЗДҮАХ-ийн 6.1.11. ХАХТ-ний 6.1.11.1. НСТ-ний 6.1, ХБХГ-ын СТ-ний 6.1.11*) | | | | | | | |
| 1.6.1 | 2002 оноос өмнө баригдсан орон сууц болон олон нийтийн зориулалттай барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах ажлыг үргэлжлүүлнэ. | - | Паспортжуулсан барилгын тоо | Паспортжуулсан барилга 934 | 952 /18 барилга нэмж паспортжуулсан байна/ | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны А/11 дүгээр захирамжийн хүрээнд олон нийтийн орон сууцны зориулалт бүхий 18 барилгад газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээ хийсэн. Дээрх 18 барилгаас:<br>✓ Тэсвэртэй барилга – 1,<br>✓ Тэсвэргүй барилга – 8,<br>✓ Хүчитгэх барилга – 9. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.6.2 | Барилга байгууламжийг паспортжуулан газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийж, лаборатори байгуулах ажлын хүрээнд Техникийн хяналтын байгууллагын MNS ISO/IEC 17020:2013 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. | - | Баримт бичгийн тоо | - | 2 | Тус ажлын хүрээнд бэлтгэл ажлыг хангаж багаж тоног төхөөрөмжийн судалгааг гарган ажиллаж байна. | 30 |
| 1.6.3 | Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, олон нийтийн барилгын хүчитгэлийн зураг, стандартын шаардлага хангасан амины орон сууцны нэг маягийн загвар зураг боловсруулна. | - | Захирамжийн тоо | - | 1 | Монгол Улсын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэх төслийн 2 дугаар үе шатны ажил эхлэхтэй холбоотой 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Япон Улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагын төлөөлөлтэй уулзаж, барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчин, бодлого, норм дүрэм, хүчитгэх үйл ажиллагаа, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх талаар санал солилцов. Тус уулзалтаар 5 барилгын байршлыг сонгон хүчитгэлийн зураг боловсруулахаар болсон. Төсөл 2022-2026 онд хэрэгжинэ. | 30 |
| | | 100.0 | Нэг маягийн зургийн тоо | - | 10 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/554 дүгээр захирамжаар Гамшигт тэсвэртэй амины орон сууцны нэг маягийн 10 төрлийн загвар зураг боловсруулах ажилд 100 сая төгрөг батлагдсан. Нийслэлийн Худалдан, авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт зарлаж, “Эм Эм Инженеринг” ХХК шалгарч, гэрээ байгуулсан. Эцсийн тайланг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хүлээн авах байснаас “Эм Эм Инженеринг” ХХК-ийн гэрээ сунгах хүсэлтийн дагуу гэрээний хугацааг сунгасан. 2023 оны 05 сарын 01-ний өдөр эцсийн тайланг хянан, Нийслэлийн Засаг даргын Тамгын | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст 2023 оны 01/07/1047 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Нэг маягийн зураг төслийг иргэд, олон нийтэд нээлттэй ашиглуулахад бэлэн болсон. | |
| *НЗДҮАХ-ийн 6.2. Монгол Улсын үндэсний түвшиний хөгжлийн бодлоготой нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулж, хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж түс орон нутгийн хөгжлийн уялдааг хангуулна.* | | | | | | | |
| Зорилт 7. Дагуул хаяа хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлэн хотын төвлөрлийг сааруулна. (*ЗГҮАХ-ийн 3.7.4, НЗДҮАХ-ийн 6.2.1, НХЖТ-ийн 5.2.2. НСТ-ний 6.2, ХБХГ-ын СТ-ний 6.2.1)* | | | | | | | |
| 1.7.1 | Улаанбаатар хотын дагуул, хаяа хот, тосгодын төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ. | 422,3 | Баримт бичгийн тоо | 11 дагуул хот, тосгодын ХЕТ батлагдсан | 3- /Жаргалант, Рашаант, 361 гарам/ | Хөрөнгө шийдвэрлэгдээгүй.<br>Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгуулахаар 2023 оны 01/01/1324 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн. | 30 |
| 1.7.2 | Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр аж ахуй нэгжийг хотоос шилжүүлэх нэгдсэн бодлого боловсруулна. | - | Баримт бичгийн тоо | УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/ | 1 | Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгуулахаар 2023 оны 01/01/1324 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн. | 30 |
| *НЗДҮАХ-ийн 6.3.Улаанбаатар хотын хөгжлийг хангасан, стандартад нийцсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.* | | | | | | | |
| Зорилт 8. Улаанбаатар хотын авто замын үндсэн сүлжээг хөгжүүлнэ. Гол, туслах гудамж замыг шинээр барьж, өргөтгөн шинэчилнэ. (*НЗДҮАХ-ийн 6.3.1, 6.3.1.1, ХАХТ-ний 6.3.1. НСТ-ний 6.3)* | | | | | | | |
| 1.8.1 | "Яармаг дэд төвийг Баянхошуу дэд төвтэй босоо тэнхлэгээр холбох 5.5 км авто зам", "Цэцэрлэгт хүрээлэн" төслүүдийг хэрэгжүүлэхэд хамтран оролцоно. | - | Загвар зураг төсөл батлагдсан байх | НИТХТ-ийн 2020 оны 02/09, 02/10 дугаар тогтоол | Тийм | Яармаг дэд төвийг Баянхошуу дэд төвтэй босоо тэнхлэгээр холбох 5.5 км авто замын ажлын Архитектур төлөвлөлтийн даалгавар МЗХ2022/36-031 дугаартай батлагдсаны дагуу Загвар зураг төслийг хянан зөвшилцсөн. | 100 |
| Зорилт 9. Голуудын эрэг болон үерийн хамгаалалтын далан, суваг, шугам сүлжээг шинээр барих болон өргөтгөн шинэчилнэ. *(НЗДҮАХ-ийн 6.3.21, ХАХТ-ний 6.3.21.1. НСТ-ний 6.5, ХБХГ-ын СТ-ний 6.3.21)* | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.9.1 | Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн НИТХ-д өргөн барьж батлуулна. | - | Мастер төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө | Эхлэл, дунд, эцсийн тайланг МЗХ-аар хүлээн авсан | 1 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 65 дугаар тогтоолоор "Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө" батлагдсан. | 100 |
| 1.9.2 | Жаргалантын амны үерийн хамгаалалтын сувгийг ашиглалтад оруулах, гүйцэтгэлийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгуулах, хамгаалалтын зурвасыг тогтоон баталгаажуулна. | 4,615.1 | Ашиглалтад орох үерийн суваг урт, км | 1,8 км сувгийн зураг зөвшилцсөн | 1,8 | Хан-Уул дүүргийн 8, 21 дүгээр хорооны Жаргалантын амны үерийн хамгаалалтын сувгийн зураг төсөл боловсруулах даалгаврыг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 03 дугаар хурлаар хэлэлцүүлэн баталсан. Тус ажлын хүрээнд 1,8км үерийн хамгаалалтын далан сувгийн ажлын зураг төсөл зөвшилцсөн. 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажил хийгдэж байна. Шугам сүлжээний мэдээллийг Хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. | 100 |
| 1.9.3 | Нисэхийн үерийн хамгаалалтын сувгийг ашиглалтад оруулах, гүйцэтгэлийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгуулах, хамгаалалтын зурвасыг тогтоон баталгаажуулна. | 6,495.0 | Өргөтгөх үерийн суваг урт, км | 1,3 км сувгийн зураг зөвшилцсөн | 1,3 | Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Нисэхийн үерийн хамгаалалтын сувгийн 1.1 км ажлын зураг төсөл зөвшилцсөн. Барилга угсралтын ажлыг ГУББГ, ОНӨААТҮГ гүйцэтгэхээр Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газартай гэрээ байгуулан ажиллаж байна. | 100 |
| 1.9.4 | Зам талбайн ус зайлуулах сүлжээг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгуулах, хамгаалалтын зурвасыг тогтоон баталгаажуулна. | 5,000.0 | Нэмэгдүүлэх сүлжээний урт, км | 190 | 199 | - Геодези усны барилга байгууламжийн газрын захиалгаар Нийслэлийн Замын Сангийн хөрөнгөөр 4 байршилд хийгдэх ус зайлуулах шугамын даалгаврыг Мэргэжлийн Зөвлөлийн 10,11 дүгээр хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Ажлын зургийн даалгавар боловсруулагдаж байна.<br>- Ус зайлуулах шугам сүлжээний ажлын зураг төсөл 3 байршилд батлагдсан. Үүнд:<br>✓ Хан-Уул дүүргийн 3 хороо,<br>✓ Хан-Уул дүүргийн 4 хороо, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны ус зайлуулах шугам сүлжээ. Шугам сүлжээний мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. | |
| 1.9.5 | Хөрсний ус зайлуулах шүүрүүлийн байгууламжийн сүлжээг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгуулах, хамгаалалтын зурвасыг тогтоон баталгаажуулна. | 500.0 | Барилга угсралтын ажлын хувь | 24 | Зөвшилцсөн ажлын зургийн тоо, урт, км | Чингэлтэй дүүргийн 7-р хороо Сервис центрийн бохирын цэвэрлэх байгууламжаас гарах саарал усыг цуглуулах цөөрмийн ажлын хүрээнд 380 метр гаргалгааны суваг, хөрсний усны шугамын ажлын зураг төсөл зөвшилцсөн. | 100 |
| 1.9.6 | Туул голын эргийн хамгаалалтын далан сувгийн ажлын зураг төслийг зөвшилцөн хот байгуулалтын мэдээллийн санд тусгуулах, хамгаалалтын зурвасыг тогтоон баталгаажуулна. | - | Ажлын зураг гүйцэтгэх хамгаалалтын далан урт, км | Хамгаалалтын далангийн ажлын зургийн даалгавар олгосон | Зөвшилцсөн ажлын зургийн тоо, урт, км | - Туул голын үерийн хамгаалалтын далан сувгийн засвар шинэчлэлтийн ажил хийгдэнэ. Ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 11 дүгээр хурлаар хэлэлцүүлэн баталсан. Ажлын зураг төслийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Хайдродизайн прожект” ХХК шалгарсан. Ажлын зураг төслийн урьдчилсан трассыг хянан шалгаж байна. Зам тээврийн хөгжлийн яамны 2023 оны 03/2004 дугаартай албан бичгийн дагуу Шинэ тойрог зам болон бусад төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан трассыг нягтлах шаардлагатай тул ажлын зураг төсөл зөвшилцөх ажил хүлээгдэж байна.<br>- 1,7 дугаар хэсгийн 6,0 км үерийн хамгаалалтын сувгийн ажлын зураг төсөл зөвшилцсөн. | 100 |
| Зорилт 10. Ус хангамжийн усан сан, шугам сүлжээг шинээр барина. (*НЗДҮАХ-ийн 6.3.23. ХАХТ-ний 6.3.24.1, НХЖТ-ний 5.3.11, 5.3.12, 5.3.13, 5.3.14, 5.3.15, 5.3.16, 5.3.17, 5.3.18, 5.3.19, 5.3.21, 5.3.22, 5.3.25, НСТ-ний 6.6, ХБХГ-ын СТ-ний 6.3.24)* | | | | | | | |
| 1.10.1 | Газрын доорх усны баруун эх үүсвэрийн ажлыг үргэлжлүүлэх, батлагдсан зураг төсөл болон гүйцэтгэлийг хот | МСС буцалтгүй тусламж | Төслийн хэрэгжилт, хувь | 10 | 30 | Тус ажлыг Мянганы сорилтын сангийн хөрөнгөөр гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд ажлын зураг төсөл зөвшилцсөн. Био комбинатаас цэвэршүүлэх үйлдвэр, Шувуун фабрикаас цэвэршүүлэх үйлдвэр, цэвэршүүлэх үйлдвэрээс | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулалтын мэдээллийн санд тусгуулах, хамгаалалтын зурвасыг тогтоон баталгаажуулна. | | | | | Баянголын аманд байрлах төвийн цэвэр усны ф600 мм -ийн шугамд холбогдох ажлын зургийн зөвшилцсөн трассыг хот байгуулалтын мэдээллийн санд оруулсан. Мөн төслийн хэмжээнд ажлын зургийн материалыг нууцад бүртгэн байгууллагын нууцын эрхлэгчид хүлээлгэн өгсөн. Барилга угсралтын ажил гэрээний дагуу хийгдэж байна. | |
| 1.10.2 | Хаягдал ус дахин боловсруулах төслийн ажлын зураг төслийн даалгавар боловсруулах, зураг төсөл зөвшилцөн хот байгуулалтын мэдээллийн санд тусгуулах, хамгаалалтын зурвасыг тогтоон баталгаажуулна. | МСС буцалтгүй тусламж | Мэдээллийн санд тусгах шугамын урт | - | 10,1 км шугам Насос станц-1 | - Мянганы сорилтын сангийн буцалтгүй тусламжаар баригдаж байгаа ус цэвэршүүлэх үйлдвэрийн барилга байгууламжийн хүрээнд цэвэршүүлсэн усыг үйлдвэрлэлд ашиглах чиглэлээр ус дамжуулах шугам хоолой, ДЦС-3, 4-ийн модификацын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг ХБНГУ-ын Фихтнер Ватер энд Транспортейшн компани, Монгол талаас Икон ХХК гүйцэтгэсэн. Төв цэвэрлэх байгууламжаас гарсан усыг дахин цэвэршүүлж дулааны цахилгаан станцуудын технологийн усны хэрэглээнд ашиглах ф1000 мм ийн голч бүхий технологийн усны шугам сүлжээний барилга угсралтыг хийхээр MCS ХХК гүйцэтгэгчээр ажиллаж байна.<br>- Мэргэжлийн Зөвлөлийн 6 дугаар хурлаар Хаягдал ус дахин боловсруулах төслийн ажлын зургийн даалгаврыг хэлэлцүүлэн дэмжигдсэн. Ажлын зургийн даалгаврыг боловсруулан баталгаажуулсан. Цэвэршүүлсэн ус ф700-1000 мм-ийн 10 км цэвэршүүлсэн усны шугам, насос станцын байршлын ажлын зургийн трассыг хот байгуулалтын мэдээллийн санд оруулсан. Ажлын зураг төслийг "Икон консалтинг" ХХК гүйцэтгэсэн. | 100 |
| 1.10.3 | Туул усан цогцолбор төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэх, ажлын зураг төслийг боловсруулах даалгавар боловсруулах, | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | - Туул усан цогцолборын ТЭЗҮ боловсруулах нийслэлд хэрэгжүүлэх хөгжлийн төслүүдийн жагсаалтад оруулахаар Улаанбаатар хөгжлийн корпорацад нэгдсэн танилцуулга бэлтгэн санал хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн томоохон төсөл хөтөлбөрийн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх санал боловсруулна. | | | | | жагсаалтад Туул усан цогцолборын ТЭЗҮ боловсруулах ажлын хөрөнгө оруулалтын санал хүргүүлсэн.<br>- Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний төлөвлөлтийн шийдэлд Туул усан цогцолборын барилга угсралтын ажлын санал тусгуулсан. | |
| 1.10.4 | Толгойт, их наран орчимд барих усан сан, шугам сүлжээний барилга, угсралтын ажлын гүйцэтгэлийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгуулах, хамгаалалтын зурвасыг тогтоон баталгаажуулна. | 100.0 | Нэмэгдүүлэх сүлжээний урт, км | 50 | 2x500 м3 усан сан, 14.5 км шугам | - Толгойтын усан сан, цэвэр ус, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зураг төслийг “Хайдродизайн инноваци” ХХК хийж гүйцэтгэснийг зөвшилцөн мэдээллийн санд оруулсан.<br>- Сонгинохайрхан дүүргийн 4 хороо, Их Нарангийн авто зам дагуу Баянхошуу коллектор хүртэл хийгдэх ариутгах татуургын ф300мм - ийн 2,8 км шугамын барилга угсралтын ажил хийгдсэн.<br>- Их Нарангийн усан сан, ус хангамжийн шугам сүлжээний барилга угсралт хийгдэж, Улсын комисс ажиллан байнгын ашиглалтад хүлээн авсан.<br>- Сонгинохайрхан дүүргийн 2, 3, 26, 35, 36 хороо Толгойт, Их Нарангийн гэр хорооллын ус хангамжийн шугам сүлжээ, усан сан, насос станцын ажлын зураг төслийг баталгаажуулав.<br>Шугам сүлжээний мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. Их Нарангийн усан сан, ус хангамжийн шугам сүлжээний барилга угсралт хийгдэж байна. | 100 |
| 1.10.5 | ”Буянт-Ухаа”-2 хороолол орчимд барих усан сан, шугам сүлжээний ажлын барилга угсралтын гүйцэтгэлийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгуулах, хамгаалалтын | 1,678.1 | Усан сан, шугам сүлжээний урт, км | Ажлын зураг төсөл батлагдсан | 2x500 м3 усан сан, 1.1 км шугам | Буянт-Ухаа-2 хорооллын орчимд Хан-Уул дүүргийн 8-р хороонд шинээр төлөвлөгдөж байгаа Хууль зүй, дотоод хэргийн яамны орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажлын зургийн даалгавар батлагдсаны дагуу цэвэр бохир усны шугам сүлжээний ажлын зургийн трасс зөвшилцөх ажил хийгдэж байна.<br>Шугам сүлжээний мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зурвасыг тогтоон баталгаажуулна. | | | | | Зураг төслийн хүрээнд шинээр төлөвлөж буй усан сангийн байршлын газар олголтын асуудлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар шийдүүлсний дараа зураг төслийг зөвшилцөхөөр хүлээгдэж байна. Ус хангамжийн шугам сүлжээний насос станц, ус дулаан хуваарилах төвийн газар олголтын асуудлыг нийслэлийн Газрын алба шийдвэрлэсэн. | |
| 1.10.6 | "Залуус-1" орон сууцны хороололд барих усан сан, шугам сүлжээний ажлын барилга угсралтын гүйцэтгэлийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгуулах, хамгаалалтын зурвасыг тогтоон баталгаажуулна. | 3,597.4 | Усан сан, шугам сүлжээний урт, км | Ажлын зураг төсөл батлагдсан | 2х1000м3 усан сан, 4.1 км шугам | Залуус-1 орон сууцны хорооллын усан сан, шугам сүлжээний ажлын зураг төслийг зөвшилцсөн. Шугам сүлжээний мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. Одоогийн байдлаар инженерийн шугам сүлжээний хонгилын барилга угсралтын ажил хийгдэж байна. Захиалагчийн хяналтыг Барилга, хот байгуулалтын яам хийж байна. Шугам сүлжээний мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. | 100 |
| 1.10.7 | Зайсан орчмын орон сууцны хороололд барих усан сан, шугам сүлжээний ажлын барилга угсралтын гүйцэтгэлийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгуулах, хамгаалалтын зурвасыг тогтоон баталгаажуулна. | 4,300.0 | Усан сан, шугам сүлжээний урт, км | Ажлын зураг төсөл батлагдсан | 2х1000м3 усан сан, 3.4 км шугам | - Зайсан орчмын орон сууцны хороололд барих усан сан, шугам сүлжээний ажлын барилга угсралтын ажил хийгдэж байна. Захиалагчийн хяналтыг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар хариуцан ажиллаж байна.<br>- Зайсангийн гүүрийг шинэчлэх ажлын хүрээнд баригдаж байгаа гүүрэн байгууламжийн ажилтай уялдуулан цэвэр бохир усны шугам хоолойг байршуулах ажлын зураг төслийг зөвшилцсөн. Хан-Уул дүүргийн 11 хорооны нутаг дэвсгэрт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй Зайсан орчмын хотхонуудын усан хангамжийн төвлөрсөн систем (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг)-ийн угсралтын ажлыг эрчимжүүлэх, ашиглалтад оруулах асуудлаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн Барилга хот байгуулалтын яаманд байгуулагдан ажиллаж байна. Шугам сүлжээний мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.10.8 | Ариутгах татуургын Туул-1 коллекторын 3,4 дүгээр ээлжийн ажлын зургийн өөрчлөлтийг зөвшилцөн хот байгуулалтын мэдээллийн санд тусгуулах, шугамын трасст баригдсан барилгад мэдэгдэл хүргүүлж чөлөөлөлтийн арга хэмжээ авна. | 1,000.0 | Өөрчлөлт хийх шугамын урт 9,4 км | Ажлын зураг төсөл боловсруулах гэрээ байгуулагдсан | 9,4 км шугам | - “Туул-1” коллекторын 3 дугаар ээлжийн барилгын зургийн өөрчлөлтийг “Мон хидро констракшин” ХХК гүйцэтгэж байна. Захиалагчийн хяналтыг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар хариуцан ажиллаж байна. “Туул-1” коллекторын трасст орсон иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийн мэдээллийг гаргаж, ажлын зургийн өөрчлөлтөд тусгуулан ажиллаж байна. Барилга, хот байгуулалтын Сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс өгөгдсөн үүрэг даалгаврын хүрээнд бохир усны шугамын барилга угсралтын ажлыг явуулахад шаардлагатай трассын өөрчлөлтийг зөвшилцөж байна. Шугам сүлжээний мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. Захиалагчийн хяналтыг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар хариуцан ажиллаж байна.<br>- Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын захиалгатай төлөвлөлтийн замын ажлын хүрээнд “Туул-1”- ийн 2 дугаар хэсгийн одоо ашиглагдаж байгаа ф800-100мм-ийн шугам сүлжээг зөөж шилжүүлэх ажлын зураг төсөл зөвшилцсөн. Шугам сүлжээний мэдээллийг Хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан байна. | 100 |
| 1.10.9 | Ариутгах татуургын Толгойт-2 коллекторын ажлын зургийн өөрчлөлтийг зөвшилцөн гүйцэтгэлийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгуулах, хамгаалалтын зурвасыг тогтоон баталгаажуулна. | 1,264.3 | шугамын урт 0,9 км | Ажлын зураг төсөл боловсруулах гэрээ байгуулагдсан | 0,9 км шугам | Толгойт дэд төвийн инженерийн шугам сүлжээний ажлын тоо хэмжээнд Толгойт-2 коллекторын өөрчлөлтийн хэсгийг оруулж хийхээр зөвшилцсөн. Ажлын зураг төсөл батлагдсан. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр дулааны шугам сүлжээний ажлын гүйцэтгэлийг Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл хөтөлбөр төслийн нэгж хариуцан хийнэ. Шугам сүлжээний мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. | 100 |
| 1.10.10 | “Буянт-Ухаа”-2 хороолол орчмын | 1,573.0 | шугамын урт 1,7 км | Ажлын зураг төсөл | 1,7 км шугам | Буянт-Ухаа-2 хорооллын 2 дугаар ээлжийн төслийн ариутгах татуургын шугамын 1,3 дугаар | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ариутгах татуургын гол шугамын ажлын гүйцэтгэлийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгуулах, хамгаалалтын зурвасыг тогтоон баталгаажуулна. | | | боловсруулах гэрээ байгуулагдсан | | ээлжийн ажлын зураг төсөл ф500/ф600 мм-ийн 2.1 км шугамын ажлын зураг төсөл зөвшилцсөн. Шугам сүлжээний хоёр дугаар ээлжийн ажлаас Буянт-Ухаа -2 хорооллын хэсэгт шугамын барилга угсралтын ажил хийгдэж дууссан. Шугам сүлжээний мэдээллийг Хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. | |
| 1.10.11 | Дарь-Эхийн гэр хорооллын төвлөрсөн ариутгах татуургын шугамын ажлын гүйцэтгэлийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгуулах, хамгаалалтын зурвасыг тогтоон баталгаажуулна. | 1,573.0 | шугамын урт 2,3 км | Ажлын зураг төсөл боловсруулах гэрээ байгуулагдсан | 2,3 км шугам | Дарь-Эхийн гэр хорооллын төвлөрсөн ариутгах татуургын шугамын ажлын зураг төсөл 2021 онд зөвшилцсөн. Шугам сүлжээний мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. 2022 оноос эхлэн шугамын барилга угсралтын ажлыг Улсын төсвийн хөрөнгөөр “Бумбод” ХХК гүйцэтгэж байна. Гүйцэтгэлийн хяналтыг Барилгын хөгжлийн төв тавьж байгаа бөгөөд нийт ф300 мм-ийн шугам, төв зам дагуу 2,3 км шугам хийгдэнэ. | 100 |
| 1.10.12 | Зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлын даалгавар боловсруулах ажлыг зураг төслийг зөвшилцөх, мэдээллийн санд тусгана. | 500.0 Улсын төсөв | Ажлын зураг зөвшилцсөн тоо | - | Зөвшилцсөн ажлын зургийн тоо, урт, км | - Баянгол дүүргийн 9,10,11 дүгээр хорооны зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн ус хангамжийн сүлжээнд холбох ажлыг “Хидродизайн ХХК” гүйцэтгэж, гүйцэтгэлийн хяналтыг Барилга хөгжлийн төв хийж байна.<br>- Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11,12 дугаар тогтоолын хавсралт, Ус сувгийн удирдах газрын 2023 оны 413/23 тоот техникийн нөхцөлийн дагуу Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо, Согоотын 26-40 дүгээр гудамж, 42 га талбайд ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зургийн даалгавар боловсруулсан.<br>- Шинээр төлөвлөж байгаа усан сан, насос станцын байршил сонгох шугам сүлжээний трасс зөвшилцөх ажил хийгдэж байна. Шугам сүлжээний мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6.1 | Нийслэлийн нутаг дэвсгэрт Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөр, зээл тусламжаар хэрэгжүүлэх инженерийн дэд бүтцийн ажлын даалгавар боловсруулах, ажлын зураг төслийг хянах, зөвшилцөх, хэрэгжилтэд хяналт тавина. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | 2023 онд Улс, нийслэлийн төсөв, орон нутгийн сангийн хөрөнгөөр хэрэгжих инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах тухай хүсэлтийг холбогдох байгууллагуудаас хүлээн авч 36 асуудлыг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулав. | 100 |
| 2.6.2 | Хот дахин хөгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн инженерийн хангамжийн төлөвлөлтийн шийдлийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын тооцоо боловсруулан, холбогдох газруудад санал өгч шийдвэрлүүлэх, зураг төслийн даалгавар боловсруулан | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо Арьс ширний 26 дугаар байрыг буулган дахин барилгажуулах төслийн гадна ариутгах татуургын шугамын ажлын зураг төсөлд саналаа өгсөн.<br>- Баянгол дүүргийн 4 дүгээр хороо, давхрын 9,10 дугаар барилгуудыг буулган дахин барилгажуулах төслийн гадна цэвэр усны шугамыг зөөж шилжүүлэх, нэвтрэх сувагт оруулах ажлын зураг төсөлд саналаа өгөв.<br>- Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, Метромалл худалдааны төвийн урд байрлах 26 дугаар байрыг буулган дахин барилгажуулах төслийн гадна ус хангамж, ариутгах татуурга, | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгэлийг хянан зөвшилцөн ажиллана. | | | | | гадна дулаан хангамжийн ажлын зураг төсөл зөвшилцсөн.<br>- Эрчим хүчний яамнаас зохион байгуулсан Эрчим хүчний бодлого төлөвлөлт, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх асуудлын хүрээнд ашиглалтын шаардлага хангахгүй төсөл арга хэмжээнд шаардлагатай төсөвт өртөг, тулгамдаад байгаа асуудлын талаар танилцуулга материал бэлтгэн уулзалтад хэлэлцүүлж, санал солилцов. | |
| *ХХЧҮХ-х Зорилт 7. Хот дахин хөгжүүлэх зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд:* | | | | | | | |
| 2.7.1 | Хот суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөх, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, асуудлыг зохион байгуулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөж барилгажуулах төслийн хүрээнд нийт 25 багцын 72 барилгад дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах төслийн санал авах урилгыг 1 дүгээр улиралд олон нийтэд нээлттэй 2 удаа зарлах ажлыг зохион байгуулав.<br>- Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх 1-48, 2-48, 4-48, 3-20 дугаар байр, Баянзүрх дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх ХАА-27 дугаар байр, Сүхбаатар дүүрэг 10 дугаар хороо хорооны нутаг дэвсгэр дэх 1, 2, 3, 4, 6, 9, 10 дугаар байр зэрэг ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин төлөвлөн барилгажуулах, орон сууцыг орон сууцаар солих замаар чөлөөлөх, чөлөөлсөн талбайд түрээсийн орон сууцны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохион байгуулан ажиллахыг "Нийслэлийн Орон сууцны корпораци" ХК-д шилжүүлсэнтэй холбоотой барилгажилтын төсөл, төлөвлөгдсөн инженерийн шугам сүлжээний талаарх мэдээ мэдээллээр хангаН ажиллаж байна.<br>- Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журмын | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3.5.”Журмын 3.4-т заасан хүсэлтийг тухайн орон сууц өмчлөгчийн 80-аас доошгүй хувь дэмжсэн тохиолдолд төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг энэ журмын дагуу зохион байгуулна. Тухайн орон сууцны барилгад хоёр буюу түүнээс дээш үл хөдлөх эд хөрөнгө өмчилж, эзэмшиж буй этгээд төсөл хэрэгжүүлэх талаар саналын нэг эрхтэй” заалтын хүрээнд 4 дүүргийн 64 барилгын санал хураалтыг нэгтгэн дүгнэж, Чингэлтэй дүүргийн 40 барилгаас 25 барилгын санал 80-аас дээш хувь хүрсэн. Налайх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх ашиглалтын шаардлага хангахгүй нь тогтоогдсон 32 дугаар байрыг дахин төлөвлөн барилгажуулах шийдвэр гаргуулахаар захирамжийн төсөл боловсруулав.<br>- Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/337 дугаар захирамжаар Баянгол дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай 35, 36 дугаар байрны барилгын төсөл хэрэгжүүлэгчээр “Уран проект” ХХК-ийн талаар сууц өмчлөгчдөөс ирүүлсэн гомдлын дагуу сууц өмчлөгч, иргэн, хуулийн этгээд, төсөл хэрэгжүүлэгч нарын хамтарсан уулзалтыг 2023 оны 09 дүгээр сарын 22, 24-ний өдрүүдэд Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс зохион байгуулав. Уулзалтаар төсөл хэрэгжүүлэгчийн саналыг дэмжиж байгаа эсэх талаар санал асуулга явуулж, дүгнэлтийг холбогдох газруудад хүргүүлэв. | |
| 2.7.2 | Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулна. | - | Төсөл хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулалт зарлах тоо | 1 | 2 | Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг дахин төлөвлөж барилгажуулах төслийн хүрээнд нийт 25 багцын 72 барилгад дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах төслийн санал авах урилгыг Газраас 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр нээлттэйгээр зарлан, 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр хүлээн авсан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Зарлагдсан 7 багцад нийт 12 хуулийн этгээдээс санал ирсэн бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1460 дугаар захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хороо саналыг хүлээн авч, 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, үнэлгээний хорооны дүгнэлтээр 5 хуулийн этгээдийг төсөл хэрэгжүүлэгчээр батламжилж, төсөл хэрэгжүүлэх эрх олгосон. Нийслэлийн Засаг дарга шалгарсан төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлав. | |
| 2.7.3 | Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөн барилгажуулж, орон сууцыг ашиглалтад оруулна. | - | Ашиглалтад оруулах барилгын өрхийн тоо | 2855 | 3000 | 2023 онд 307 айл өрхийн 3 орон сууц ашиглалтад орсон. Үүнд:<br>✓ Баянгол дүүргийн 4 хороо, 82 айлын 2 давхар орон сууцыг буулган, 168 айл өрхийн 16 давхар орон сууц,<br>✓ Хан-Уул дүүргийн 2 хороо 18 айлын 2 давхар орон сууцыг буулган, 91 айл өрхийн 16 давхар орон сууц,<br>✓ Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо, 12 айлын 2 давхар орон сууцыг буулган, 48 айл өрхийн 10 давхар орон сууц. | 100 |
| 2.7.4 | Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгнө. | - | Саналын тоо | 1 | 1 | - Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөний тодотголд тусгуулах 81 байршлын саналыг 2023 оны 3/529 дугаартай албан бичгээр хүргүүлэв.<br>- Нийслэлийн Газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөөний төсөлд саналаа албан бичгээр хүргүүлсэн.<br>- Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас болон жилийн эцсийн байдлаар тайлагнав. | 100 |
| *ХХЧҮХ-х Зорилт 8. Барилгын ажлын зөвшөөрөл олгох ажлын хүрээнд:* | | | | | | | |
| 2.8.1 | Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Барилгын ажлыг | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, бусад холбогдох хууль, норм, стандарт, Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлыг эхлүүлэх, | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгоно. | | | | | үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм"-д заасны дагуу Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 966 иргэн, хуулийн этгээдэд Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг олгов. Баримт бичгийн бүрдэл дутуу, шаардлага хангахгүй иргэн, хуулийн этгээдийн 436 хүсэлтийг буцаасан.<br>- Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм", Газрын даргын 2023 оны А/10 дугаар тушаалын дагуу Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 288 барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаанд оролцож, Архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зургийн хүрээнд барилгын ажил гүйцэтгэсэн эсэхэд хяналт тавьж, комиссын дүгнэлтэд санал тусгуулж ажиллав. | |
| 2.8.2 | Нийслэлийн нутаг дэвсгэрт Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл тусламжаар хэрэгжүүлэх инженерийн дэд бүтцийн ажлын барилга угсралтын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгоно. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх инженерийн шугам сүлжээний угсралтын 28 ажилд Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгов. | 90 |
| 2.8.3 | Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд олгосон Барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийн хүрээнд Барилга, байгууламжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ, орчны | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/01 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд 320 иргэн, хуулийн этгээдэд "Барилгын талбайн түр хашаа MNS5414:2004" стандартад заасны дагуу инженерийн бэлтгэл арга хэмжээг хангуулж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх талаар Хотын стандарт, хяналтын газраас гаргасан зөвлөмжийг хүргүүлж ажиллав. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аюулгүй байдал болон хөдөлмөр хамгаалалтыг хангуулж ажиллана. | | | | | | |
| 2.8.4 | Барилгын ажлын явцад үүссэн хот байгуулалт, төлөвлөлттэй холбоотой зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэн ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Нийслэлийн нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүйгээр барилгын ажил гүйцэтгэж байгаа 77 иргэн, хуулийн этгээдэд илэрсэн зөрчлийг арилгах талаар албан шаардлага, мэдэгдэл хүргүүлж, илэрсэн зөрчилд холбогдох арга хэмжээ авч хамтран ажиллах талаар Хотын стандарт, хяналтын газарт 2023 оны 9/467, 9/484, 9/602, 9/607 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлэв. | 100 |
| 2.8.5 | Барилга, байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэн барих, буулгах ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд оруулж, цахим архив үүсгэж ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгосон 966 барилга байгууламжийн хаяг байршил, захиалагч, зураг зохиогч, гүйцэтгэгчийн мэдээллийг Хот байгуулалтын мэдээллийн менежментийн eBarilga.ub.gov.mn нэгдсэн системд бүртгэлжүүлэн, цахим архив үүсгэв. | 90 |
| 2.8.6 | Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд олгосон Барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийн хүрээнд хот байгуулалтын мэдээллийн сангийн зураглал, мэдээлэл бэлтгэж ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Хот байгуулалтын мэдээллийн сангийн E-barilga системд бүртгэлтэй Барилгын ажлын зөвшөөрлийг Qgis программтай холбож нэвтрүүлснээр Нийслэл, дүүрэг тус бүрээр зураглал бэлтгэж, kmz өргөтгөлөөр бэлтгэв. | 100 |
| *ХХЧҮХ-х Зорилт 9. Дотоод хяналт, хуулийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд:* | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.9.1 | Газрын эрхлэн явуулж буй үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, газрын үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай холбогдох дүрэм, журмын төслийг боловсруулж, санал өгнө. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Газрын эрхлэн явуулж буй үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд 13 захирамжлалын баримт бичиг боловсруулан батлуулав. Үүнд:<br>✓ Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тогтоолын төсөл- 1<br>✓ Нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл -12<br>- "Газрын ёс зүйн дүрэм"-ийн төсөл, "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын төслийг боловсруулж, Захиргааны зөвлөлийн 2023 оны 12 дугаар хурлаар танилцуулж, алба хаагчдаас санал авч төслийг батлуулахаар бэлтгэн ажиллаж байна.<br>- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын өргөдөл гомдол шийдвэрлэх журам"-ыг нийт алба хаагчдад танилцуулж, Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хуулийн талаарх мэдээллийг нийт алба хаагчдад мэдээлэв.<br>- Газрын даргын захирамжлалын болон бусад захиргааны актад кодификаци хийх ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хүрээнд Архитектур төлөвлөлтийн 738 даалгавар, 20 загвар зурагт кодификаци хийв. Мөн Газрын даргын 2018-2022 оны хооронд гарсан А тушаалуудад хяналт тавин шаардлагатай кодификаци хийж ажиллав.<br>- Холбогдох баримт баримт бичиг, хуулийн төсөл, дүрэм журамд санал хүргүүлэв. Үүнд:<br>✓ Норм, нормативын баримт бичиг 13,<br>✓ Хуулийн төсөл 15,<br>✓ Дүрэм журам 24,<br>✓ Журам 1. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгч, хэлэлцүүлэг зохион байгуулсан ба Хуулийн төслийн хэлэлцүүлгийг нийслэлийн 9 дүүрэгт танилцуулсан бөгөөд ажлын хэсгийн хуралд оролцов.<br>- Барилгын тухай хуулийг шинэчлэх ажлын хүрээнд 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ, мониторинг хийх үүрэг бүхий ажлын хэсэгтэй хамтран Барилгын тухай хуулийг хэрэглэхэд тулгарч буй асуудлын талаарх хэлэлцүүлгийг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт 36 алба хаагч хамрагдав. | |
| *ХХЧҮХ-х Зорилт 10. Хот байгуулалтын талаар хууль, дүрэм, журам холбогдох баримт бичигт санал тусгаж ажиллах* | | | | | | | |
| 2.10.1 | Нийслэл хотын эдэлбэр газрыг тогтооно. | - | Саналын тоо | - | 1 | Нийслэл хотын эдэлбэр газрыг тогтоох саналыг холбогдох газруудаас авч байна. | 30 |
| 2.10.2 | Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл тогтоох шалгуур үзүүлэлтийг боловсруулна. | 350,0 | Баримт бичгийн тоо | - | 1 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/113 дугаар захирамжаар Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг 2022 онд 3 удаа хуралдаж Нийслэлийн Газар зохион байгуулалтын албатай хамтран эрдэмтэн судлаачидтай уулзалт зохион байгуулж газрын төлбөрийн бүсчлэлийн талаар мэдээлэл солилцон ажилласан. Улмаар 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар Нийслэлийн тэг гортиг бүхий эдэлбэр газрын бүсчлэл тогтоох шалгуур үзүүлэлт, эдэлбэр газрын бүсчлэл, бүсчлэлийн дүрмийн төслийг боловсруулах ажлын талаар Улаанбаатар хотын Ерөнхий Архитектор Н.Нацагдорж танилцуулга хийж, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/-тай уялдуулан боловсруулахаар хойшлуулав. | 100 |
| 2.10.3 | Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл, бүсчлэлийн дүрмийг боловсруулна. | | | - | 1 | | |
| 2.10.4 | Дагуул хот байгуулах дүрэм, эдийн засгийн | - | Саналын тоо | 1 | 1 | - Эдийн засаг, хөгжлийн яамнаас зохион байгуулсан "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тусгай бүс байгуулах ажилд санал өгнө. | | | | | үзэл баримтлал"-ын төсөлд Нийслэлийн тусгай чиг үүрийг хэрэгжүүлэхэд стратегийн ач холбогдол бүхий дагуул хот, тосгон, эдийн засгийн тусгай бүсүүдийг байгуулж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх хэлэлцүүлэгт оролцож, саналаа өгсөн.<br>- Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1243 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу байршлын судалгаа хийж, төлөвлөлтийн хилийг гаргаж, хот байгуулалтын асуудлуудад санал өгч ажиллав. | |
| 2.10.5 | Хот байгуулалт, барилга, стандарт, хяналт, зохицуулалтын дүрэм, журам холбогдох баримт бичигт санал тусгуулж ажиллана. | - | Саналын тоо | - | 1 | Хот суурины төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбД 30-01-04/-ийг шинэчлэн боловсруулах төслийн хэлэлцүүлэгт оролцож, нормын төслийг салбар тус бүрээр нь мэргэжлийн байгууллага болон эрх бүхий шинжээчдийн оролцоог хангуулж боловсруулах, хянуулах талаар санал өгч ажиллав. | 100 |
| 2.10.6 | Гудамж, зам, талбай, барилга байгууламжийн хаягжуулалтын журам шинэчилнэ. | - | Журмын тоо | 1 | 1 | - Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга, үзэл баримтлалд 2023 оны 01/10/2930 дугаартай албан бичгээр 22 заалт бүхий санал хүргүүлсэн.<br>- Гудамж, зам, талбай, барилга байгууламжийн хаягжуулалтын журам шинэчлэх ажил нь Хаягжуулалтын тухай хуулийн төслийн шинэчлэлийн ажилтай уялдахаар бэлтгэгдэж байна. | 100 |
| 2.10.7 | Байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбоотой хот байгуулалтын гэрээ, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин барилгажуулах төсөлд оролцогч талуудтай | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нь тогтоогдсон нийтийн зориулалттай орон сууцыг дахин барилгажуулах төсөл боловсруулж, барилга угсралтын ажил гүйцэтгэх төсөл хэрэгжүүлэхээр гурван талт гэрээ байгуулсан 24 компанийн 907 гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллав. Шинээр 3 төсөл хэрэгжүүлэгчийн гурван талт 102 гэрээ байгуулсан.<br>- Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг буулган дахин | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гэрээ байгуулах, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, дүгнэх асуудлыг зохион байгуулна. | | | | | барилгажуулах гурван талт 953 гэрээнээс 2022 онд ашиглалтад орсон Баянгол дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэр дэх 12, 13, 15, 16 дугаар байрны төсөл хэрэгжүүлэгч “Эм Эм Жи капитал” ХХК-ийн 37 гэрээ, Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны Нэхмэлийн 3 дугаар байрны төсөл хэрэгжүүлэгч “Алтан трейд” ХХК-ийн 25 нийт 62 гурван талт гэрээг газрын архивд хүлээлгэн өгөв.<br>- Хот байгуулалтын болон дотоод үйл ажиллагааны чиглэлээр 13 гэрээ байгуулж, хуулийн хугацаанд шилэн дансанд байршуулав | |
| 2.10.8 | Газрын хэмжээнд дотоод хяналтыг зохион байгуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Нийслэлийн Засаг даргын тусгай бүрэн эрхэд Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн өөрийн болон доод шатны Засаг даргын ажлын алба, харьяа байгууллага, аж ахуйн нэгжид дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлаж мөрдүүлэх” заалтын дагуу газрын Дотоод хяналт шалгалтын журмын төслийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны 10/380 дугаар албан бичгээр хүргүүлэв.<br>- Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/727 дугаар захирамжаар баталсан ”Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг мөрдлөг болгон ажиллав. Журмын дагуу газрын Дотоод хяналт шалгалтын 2023 оны III дугаар улирлын тайланг 2023 оны 01/10/2463 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэв.<br>- Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн ажил үйлчилгээ, мэргэжил ур чадварын талаар гаргасан гомдлын дагуу хяналт, шалгалт зохион байгуулж 32 өргөдөл, гомдлын барилгын норм дүрэм хангасан эсэх, шийдвэрлэлтэд хууль зүйн үндэслэлийг тусгаж хариу өгч шийдвэрлэв. Үүнээс: Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн дагуу 14 сонсох ажиллагаа хийж, 4 | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | захиргааны акт хүчингүй болгож, 3 акт түдгэлзүүлэх шийдвэр гаргав.<br>- Газрын даргын захирамжлалын болон бусад захиргааны актад кодификаци хийх ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хүрээнд 10 Архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зурагт кодификаци хийв.<br>- Мэргэжлийн зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу үүссэн барилгын хувийн хэргийн бүрдэлд хийх хяналт, шалгалт, Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын гэрээний хэрэгжилт, явц, Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг нээлттэй байршуулсан эсэхэд хяналт шалгалт хийх ажлын удирдамжийг батлуулан хяналт шалгалт хийж, зөвлөмж гарган ажиллав.<br>- Газрын 2023 оны Дотоод хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөг Захиргааны зөвлөлийн 03 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар танилцуулав. Мөн 2022 онд хийгдсэн ажлын тайлан, дүгнэлт зөвлөмж, анхаарах асуудлын танилцуулга хийв.<br>- Хуулиар хориглосон хэм хэмжээг зөрчиж хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх авлигын зөрчил гаргахгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Барилга, байгууламжийн Архитектур төлөвлөлтийн даалгавар, Загвар зураг, Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олголттой холбоотой асуудлаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хийсэн хяналт шалгалт, цаашид дагаж мөрдөх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зөвлөмжийн танилцуулга”, 2023 оны хагас жилийн Дотоод хяналт шалгалтын ажлын тайланг 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Захиргааны зөвлөлийн 08 дугаар хуралаар | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танилцуулж, 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр төлөвлөлт хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулав.<br>- Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/727 дугаар захирамжаар баталсан ”Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”, газрын Дотоод хяналт шалгалтын ажлын 2023 оны төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд төлөвлөгөөт 7 хяналт шалгалтын ажлыг газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэн судалгаа гаргаж дүгнэлт, зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх ажлын санал гаргаж ажиллав. Үүнд:<br>✓ Мэргэжлийн зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу үүссэн барилгын хувийн хэргийн бүрдэлд хийх хяналт, шалгалт,<br>✓ Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын гэрээний хэрэгжилт, явц,<br>✓ Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг нээлттэй байршуулсан эсэх<br>✓ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан газрын төсөв, санхүүгийн мэдээллийг байршуулсан байдал,<br>✓ Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний бүрдүүлбэр, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд удирдамж гарган газрын даргаар батлуулан төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх ажлын санал гаргав.<br>✓ Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагаанд хийх дотоод хяналт шалгалтын ажлын №т2023/06 дугаар удирдамж, Шүүхээр хянан хэлэлцэгдэж тус газраас хариуцагчаар татагдсан Маргаанд дүн шинжилгээ хийх дотоод хяналт шалгалтын №Т2023/07 дугаар удирдамж газрын даргаар батлуулан хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэж байна.<br>✓ Төлөвлөгөөт бус шалгалтын ажлын хүрээнд Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын явц, график төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр нь очиж шалгах удирдамж батлуулан шалгаж дүгнэлт, зөвлөмж, гаргаж ажиллав. Гарсан дүгнэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст тайлагнав.<br>✓ Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн ажил үйлчилгээ, мэргэжил ур чадварын талаар гаргасан 122 өргөдөл, гомдлыг хууль, дүрэм, журам, барилгын норм дүрэм хангасан эсэх шийдвэрлэлтэд хууль зүйн үндэслэлийг тусгаж хариу өгч шийдвэрлэв, | |
| 2.10.9 | Газрын үйл ажиллагаанд мониторинг хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Газрын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийх хяналт шинжилгээ, үнэлгээний 2023 оны ажлын төлөвлөгөө гарган 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Газрын даргаар батлуулав. (8 арга хэмжээ) Үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хяналт шинжилгээ хийсэн бодлогын баримт бичгүүд: | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ "150 мянган айл-орон сууц" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2022 оны биелэлт,<br>✓ Монгол Улсын Хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний биелэлт, (сар бүр)<br>✓ Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны биелэлт, (сар бүр болон хагас жилийн байдлаар)<br>✓ "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн 2021-2022 оны хэрэгжилт болон хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн 2022 оны жилийн эцсийн тайлан,<br>✓ Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт,<br>✓ Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилт,<br>✓ Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт, (сар бүр болон хагас, бүтэн жилийн байдлаар)<br>✓ Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 2023/02 дугаар "Үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах тухай", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 08 дугаар "Усны сан бүхий газрын бохирдохоос хамгаалах, үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх, арга хэмжээний тухай" албан даалгаврын хэрэгжилт | |
| 2.10.10 | Хотын стандартыг хэрэгжүүлэхэд чиг үүргийн хүрээнд дэмжлэг үзүүлж, мэдээ | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд 2023 онд стандарт, норм дүрмийн хэрэгжилтийг хангуулах ажлын нэгдсэн төлөвлөгөөний дагуу "Нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх стандарт, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллээр ханган хамтран ажиллана. | | | | | шаардлага" UCS 0901B:2020, UCS 0902B:2020, UCS 1603C:2020, UCS 1601B:2020, UCS 1601C:2020, UCS 0903B:2020, UCS 0001-01:2019, UCS 1602B:2020, UCS 1602C:2020, UCS 0002-02:2019, UCS 1901B:2020, UCS 1403C:2020, UCS 1404C:2020-г тус тус мөрдөж ажиллахыг, мөн архитектур төлөвлөлтийн даалгаварт тусган ажиллав.<br>- 2023 онд Архитектур төлөвлөлтийн 504 даалгаварт Нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх, стандарт шаардлагуудыг мөрдөх талаар тусгаж, 481 Загвар зурагт норм стандартыг мөрдлөг болгон зөвшилцөж ажилласан бөгөөд дээрх мэдээллийг Хотын стандарт, хяналтын газарт 2023 оны 10/3202 дугаартай албан бичгээр тайлагнав. | |
| 2.10.11 | Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрддөг стандартыг хангуулж, мөрдлөг болгон ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Барилгын тухай, Газрын тухай, Хот байгуулалтын тухай хууль болон бусад холбогдох хууль, норм, стандарт, дүрэм, журмыг Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаа, барилгын ажлын зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллав. | 100 |
| 2.10.12 | Хууль, шүүхийн байгууллагад нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Ерөнхий архитектор болон Газрын даргын шийдвэртэй холбоотой эрх зүйн маргаанд итгэмжлэлээр оролцоно. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Иргэн, хуулийн этгээдийн нэхэмжлэлтэй Нийслэлийн Засаг даргад холбогдох 14, Нийслэлийн Ерөнхий архитектор болон тус газарт холбогдох захиргааны 77, иргэний хэргийн 7 маргаанд холбогдох материалуудыг судалж тайлбар гаргах, нотлох баримт хүргүүлэх, хэргийн материалтай танилцах, газрын үзлэг хэмжилтэд оролцох, гэрч асуухад байлцах зэрэг ажиллагаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр 81, нэхэмжлэгчээр 1, гуравдагч этгээдээр 2 удаа оролцов. Үүнээс :<br>✓ Анхан шатны 346 шүүх хурал,<br>✓ Давж заалдах шатны 79 шүүх хурал.<br>Нийт 84 хэрэг хянан шийдвэрлэх шатандаа байна. Он дамжсан 85, тайлант онд гардаж авсан 40 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаагаас тухай онд 39 хэрэг маргааны эцэслэн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шийдвэрлэв. Хэрэг маргааны шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийвэл:<br>✓ Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн хэрэг- 5,<br>✓ Зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн хэрэг -2,<br>✓ Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, Хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэрэг -2,<br>✓ Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэрэг -12,<br>✓ Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаас татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэрэг-10,<br>✓ Нэхэмжлэгч гуравдагч этгээдтэй эвлэрч, нэхэмжлэлээсээ татгалзсан, хэргийг хэрэгсэхгүй болгосон хэрэг -2,<br>✓ Нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд болохыг шүүхээс тогтоож шийдвэрлэсэн хэрэг -1. | |
| *ХХЧҮХ-х Зорилт 11. Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд:* | | | | | | | |
| 2.11.1 | Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг хангаж ажиллаж, тайлагнана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Бодлогын баримт бичиг:<br>- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2022 оны хэрэгжилт, 2020-2022 оны хэрэгжилтийн фото танилцуулгын биелэлтийг нэгтгэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны 01/01/381 дугаартай албан бичгээр,<br>- “150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2022 оны биелэлтийг Барилга, хот байгуулалтын яаманд 2023 оны 01/1/145 дугаартай албан бичгээр,<br>- Монгол Улсын Хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний биелэлтийг сар бүр гарган tungalag.o@ulaanbaatar.mn цахим хаягаар,<br>- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны биелэлтийг | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сар, улирал, жилийн эцсийн байдлаар гарган tungalag.o@ulaanbaatar.mn цахим хаягаар,<br>- "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн 2021-2022 оны хэрэгжилт болон хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн 2022 оны жилийн эцсийн тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст 2023 оны 01/1/174 дугаартай албан бичгээр,<br>- Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст 2023 оны 01/559 дугаартай албан бичгээр,<br>- Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар гарган Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст https://control.ulaanbaatar.mn/ цахим системээр,<br>- 2019-2022 онд төсвийн болон бусад хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 2023 оны 01/01/367 дугаартай албан бичгээр,<br>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг сар бүр rich.nabusa@gmail.com цахим хаягаар тухай бүр хүргүүлэн ажиллав.<br>- Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг сар, улирал, хагас жил, III улирлын байдлаар гарган хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст 2023 оны 01/01/429 дугаар албан бичиг болон цахим хаягаар хүргүүлэв. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.11.2 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, жилийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын цахим хуудсан дах мэдээллийг 2023 онд тогтмол хариуцан шинэчлэн ажиллах алба, хэлтсүүдийг 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Газрын даргаар батлуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын цахим хуудас дахь мэдээллийг 2023 онд тогтмол шинэчлэн Газрын uda.ub.gov.mn цахим хуудсанд 10 төрлийн 266 мэдээ, мэдээллийг шинэчлэн байршуулав.<br>- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын цахим хуудас дахь мэдээлэлд 2023 оны хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг хийж, Газрын захиргааны зөвлөлийн хурлаар танилцуулж, веб хуудсанд байршуулав.<br>- 2022 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, хөрөнгө оруулалтын дансны мэдээ, барьцаа дансны мэдээ, нэмэлт санхүүжилтийн дансны мэдээг хугацаанд нь гаргаж баталгаажуулав.<br>- -Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж байгууллагын төсөв, төсвийн гүйцэтгэл, төсвийн хэмнэлт, аудитын зөвлөмжийн биелэлт, санхүүгийн тайлангийн холбогдолтой 81 мэдээллийг shilendans.gov.mn сайтад оруулж ил тод байдлыг ханган ажиллав.<br>- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж цахимжуулах, нээлттэй ил тод байдлыг хангах, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд хот байгуулалтын асуудал хэлэлцдэг Мэргэжлийн зөвлөлийн 44 удаагийн хурлын явцыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан нээлттэй "LIVE" хэлбэрээр зохион байгуулдаг болсон. Тус хурлаар нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжих хот төлөвлөлтийн баримт бичиг, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн архитектур төлөвлөлтийн даалгавар, автозам, замын байгууламж, тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар олгох асуудлыг хэлэлцэхийн зэрэгцээ Загвар зураг батлах үйлчилгээг ил тод нээлттэй хэлэлцүүлдэг болов. | |
| 2.11.3 | Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг тайлагнана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Монгол Улсын Шадар Сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд байгуулах "Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ"-нд тусгах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2023 оны 01/1/91 дугаартай албан бичгээр хүргүүлэв. 2023 оны гэрээний хэрэгжилтийг 01/013405 албан бичгээр хүргүүлэв.<br>- Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2023 онд "Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах гэрээ"-нд тусгах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны 01/1/96 дугаартай албан бичгээр, хэрэгжилтийг 2023 оны хагас жилийн байдлаар гарган хүргүүлэв.<br>- Барилга, хот байгуулалтын Сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд "Засгийн газрын зарим чиг үүргийг 2023 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ"-нд тусгах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны 01/75 дугаартай албан бичгээр, гэрээний хэрэгжилтийг 2023 оны хагас жил болон жилийн эцсийн байдлаар гарган 01/01/3404 тоот албан бичгээр хүргүүлэв. | 100 |
| 2.11.4 | Газрын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, хүний нөөцийн ил тод | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Газрын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөг (8 зорилт, 20 арга хэмжээ) 2023 оны 02 дугаар | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байдлыг хангаж ажиллана. | | | | | сарын 27-ны өдөр батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас болон жилийн эцсээр тайлагнан үр дүнг нийт албан хаагчдад танилцуулж, газрын цахим хуудсанд нээлттэй байршуулав. | |
| 2.11.5 | Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөн, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, өр авлага үүсгэхгүй ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн төлөлтийн тайланг цаг хугацаанд нь цахимаар илгээн, хянуулж баталгаажуулав.<br>- Нийт 35 албан хаагчийн хөдөлмөрийн чадвараа түр алдсаны эмнэлгийн хуудасны тооцоог хийж, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст хянуулж баталгаажуулав.<br>- 2022 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, хөрөнгө оруулалтын дансны мэдээ, барьцаа дансны мэдээ, нэмэлт санхүүжилтийн дансны мэдээг хугацаанд нь гаргаж баталгаажуулсан.<br>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд туссан төлөвлөгөө, өр, авлага, санхүүжилтийн орлого, өөрийн орлого, дансны үлдэгдлийг баталгаажуулсан.<br>- 2023 оны үндсэн үйл ажиллагааны орлогыг газрын үйлчилгээ тус бүрээр ангилан задалж программд шивж баталгаажуулав.<br>- Шатахууны тооцоог сарын ажлын хоногийг үндэслэн Төр захиргааны авто баазтай баталгаажуулсны дагуу шатахууныг олгож, жолоочийн замын хуудасны тооцоог хянав.<br>- Байгууллагын данс бүртгэлтэй цаашид ашиглах боломжгүй 164,938,280.75 төгрөгийн үндсэн хөрөнгийн жагсаалтыг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлэн 2023 оны А/79 дүгээр тушаалаар шийдвэрлүүлэн, 2023 оны 10 сарын 24-ний өдрийн А/341 тушаалыг үндэслэн данс бүртгэлээс хасав. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.11.6 | Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2023 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, явц, үр дүнгийн мэдээг нэгтгэн 2023 оны 01/537, 01/01/3065 дугаар албан бичгээр хүргүүлэв.<br>- Сангийн яамнаас боловсруулсан Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.28 дахь заалтад заасан ногоон худалдан авах ажиллагааны тодорхойлолтод нийцүүлэн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр нийтлэг худалдан авдаг бараа, бүтээгдэхүүний ногоон шалгуур үзүүлэлт бүхий жишиг техникийн тодорхойлолтын төсөл болон холбогдох зааварт санал өгөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлэв.<br>- Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийслэлд хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний явцын мэдээллийг сар бүр нэгтгэж, https://erp.ulaanbaatar.mn/ цахим системээр 11 удаа тайлагнав.<br>- Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/170, А/923, 2023 оны А/73 дугаар захирамжийн дагуу улс, нийслэлийн төсвөөр санхүүжсэн он дамжсан 2 ажлын санхүүжилтийг Нийслэлийн Төрийн сангаар шийдвэрлүүлсэн. Үүнд:<br>✓ НХААГ/202212160, НХААГ/202212160-1 дугаартай " Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох,барилга барих үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй болгох ажлыг гүйцэтгэсэн "Смарт дата" ХХК-тай үлдэгдэл 20% санхүүжилт хийж тооцоог дуусгасан.<br>✓ НХААГ/202212155,НХААГ/202212155-1 дугаартай " Нийслэлийн хаягийн мэдээллийн санг шинэчлэн Улсын | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаягийн нэгдсэн системд бүрэн холбох" ажлын гүйцэтгэлд Ай Си Ти групп ХК-д 40% санхүүжилт олгосон. | |
| 2.11.7 | Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр дүнтэй зарцуулж, төсөвт байгууллагын өөрийн орлогыг хуваарийн дагуу хангaн ажиллана. | 120,0 сая төгрөг | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 133,2 сая төгрөгийн орлого олж, орлогын гүйцэтгэл 111% биелсэн. Үүнд:<br>✓ Гэрчилгээний сунгалт 950,000 төгрөг,<br>✓ Барилгын чанарын дүгнэлт 30,183,378 төгрөг,<br>✓ Барилгын ажлын зөвшөөрөл 16,180,00 төгрөг,<br>✓ Хаяг дугаар 50,196,771 төгрөг,<br>✓ Тодорхойлолтын үнэ 2,153,031 төгрөг<br>✓ Архивын лавлагаа 1,104,840 төгрөг,<br>✓ Зургийн үнэ 32,453,609 төгрөг.<br>Нийслэлийн төсвөөс 2.558,722,000.00 төгрөгийн санхүүжилт хийгдэж, 1,793,508,852.51 төгрөгийн зарлага гарсан. Үүнд:<br>✓ Цалингийн зардал 1,520,147,387.65 төгрөг<br>✓ 2.Нийгмийн даатгалын шимтгэл ажил олгогчийн зардал 182,083,872.69 төгрөг,<br>✓ 3.Нэг удаагийн тэтгэмжийн зардал 16,100,000 төгрөг,<br>✓ 4. Бичиг хэргийн зардал 10,898,482 төгрөг,<br>✓ 5.Түлш, шатахууны зардал 9,654,530 төгрөг,<br>✓ 6.Байрны түрээсийн зардал 10,624,600 төгрөг,<br>✓ 7.Засвар, үйлчилгээний зардал 11,690,180 төгрөг,<br>✓ 8.Шуудан холбооны зардал 16,280,100.17 төгрөг,<br>✓ 9. Бусад зардал 10,176,500 төгрөг. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.11.8 | 2023 оны зорилтод жилийн хүрээнд тодорхой ажил санаачилж, хэрэгжүүлнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | - Нийслэлийн Ерөнхий Архитектораас өгсөн үүрэг чиглэлийн дагуу "Сэлбэ-Сэргэлт" төслийн суурь судалгаа, төлөвлөлтийн шийдэл, хөрөнгө оруулалтын урьдчилсан тооцооллыг гаргаж танилцуулж, дэмжигдсэн. Үүнд:<br>✓ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр,<br>✓ Барилга, хот байгуулалтын Сайдад 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр,<br>✓ Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 3, 04 дүгээр сарын 12-ны өдрүүдэд.<br>- Налуу замын төслийг үргэлжлүүлэн Нийслэлийн 1 дүгээр дунд сургуульд налуу замыг төлөвлөж, сургуулийн хашаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн орох боломжтой хаалга төлөвлөн зураг төслийг боловсруулав.<br>- Нийслэлийн төвийн 6 дүүргийн барилгажсан хэсгийн нийтийн эдэлбэр газруудад тохижилтын ажлын төлөвлөлтийн концепци боловсруулан, цаашид тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар тусгайлан боловсруулдаггүй байх арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.<br>- Газрын үйл ажиллагаанд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг баримтлан иргэдтэй эелдэг харьцаж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хүргэж, төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагыг сайжруулж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Ажлын бүтээмжийг дээшлүүлэх аян"-ны удирдамжийг боловсруулан Захиргааны зөвлөлийн 1 дүгээр хурлаар танилцуулан, Газрын даргаар 1 дүгээр сарын 13-ны өдөр батлуулав. Аяны хүрээнд:<br>✓ Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, зөрчил тооцогдсон албан бичиг, газрын үйл ажиллагаа, хүний нөөцтэй холбоотой гарсан А, Б тушаалын мэдээлэл, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| --- | --- | --- | --- | --- | --- | --- | --- |
| | | | | | | шинээр томилогдсон болон ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн мэдээлэл, Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулах үндэслэл, нэмэлт өөрчлөлт оруулах талаар танилцуулга хийсэн.<br>✓ “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд анхаарах асуудал”, “Албан хэрэг хөтлөлтийн eDoc систем ашиглах журам”, “Зөвшөөрлийн тухай хуулийн танилцуулга”, “Засгийн газар дахь хяналтын тухай хууль”, “Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль”, “Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын талаар 4 удаагийн сургалт зохион байгуулсан.<br>✓ 4 гомдол, 2 талархал хүлээн авсан, 2 иргэний гомдлыг татуулж, 2 иргэний гомдлыг хянан үзэж, албан хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй тул иргэнд хариу тайлбар өгч ажиллав. 2 талархлыг холбогдох нэгж, албан хаагчдад болон нийт албан хаагчдад танилцуулсан.<br>- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж цахимжуулах, нээлттэй ил тод байдлыг хангах, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд хот байгуулалтын асуудал хэлэлцдэг Мэргэжлийн зөвлөлийн хурлын явцыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан нээлттэй “LIVE” хэлбэрээр зохион байгуулдаг болсон. Тус хурлаар нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжих хот төлөвлөлтийн баримт бичиг, барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн архитектур төлөвлөлтийн даалгавар, автозам, замын байгууламж, тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар олгох асуудлыг хэлэлцэхийн зэрэгцээ Загвар зураг батлах үйлчилгээг ил тод нээлттэй хэлэлцүүлдэг болсон. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан Шил ажиллагааны хүрээнд Газрын даргын 2023 оны А/17 тушаалаар байгуулагдсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссын 2013-202 оны 8 дугаар сар хүртэлх дүгнэлтийг архивын баримтаас шүүж, цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 2013-2020 оны нийт 2047 барилга байгууламжийн дүгнэлтийг цахим хэлбэрт шилжүүлэв.<br>- Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар, Барилга, хот байгуулалтын Сайдын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 67 дугаар тушаалаар баталсан Ажлын хэсгийн удирдамжийн дагуу Нийслэл дэх нийтийн эдэлбэр газар, усны эх үүсвэр, усан сан бүхий газар, авто зам инженерийн шугам сүлжээний хамгаалалтын бүсэд хууль тогтоомж норм дүрэм стандартыг зөрчин олгосон зөвшөөрөлтэй газарт Архитектур төлөвлөлтийн даалгавар, Загвар зураг баталсан, барилгын ажлын зөвшөөрөл олгосон үйл ажиллагаанд үзлэг хийж, нэгтгэсэн судалгаа гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг Газрын даргын 2023 оны А/18 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг 2006 оноос хойш бүртгэгдсэн 29110 барилгын мэдээллийг Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Дээрх барилгуудын 1364 барилгын мэдээллийг архиваас шүүж, маягтын дагуу бүртгэлжүүлж байна. Үүнд:<br>✓ Ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүс орсон 855 барилга<br>✓ Усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс орсон 509 барилга<br>- Газрын үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм журмын талаар иргэд, хуулийн этгээдэд зөвлөмж хүргэсэн богино хэмжээний видео | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэлтгэн газрын www.uda.ub.gov.mn цахим хуудас болон facebook хуудсанд байршуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>- Ажилгүйдлийг бууруулж гэр хорооллын хөгжлийг бий болгоход тогтвортой орлогын асуудлыг шийдвэрлэх зорилгоор "Олон нийтийн төв бүхий шинэ ажлын байр бий болгох инкубатор төв" бий болгох байршлын судалгаа хийсэн. Уг инкубатор төв нь сургалтын танхим, дадлагажуулах байр, түрээсийн ажлын талбай, хүүхэд асрах төв, цайны газар гэх мэт хэсгүүдээс бүрдэж, төр хувийн хэвшлийн түншлэлээр тус төвийг бий болгоно.<br>- Гэр бүлийн ФМ104.5 радиогийн "Нэг дусал" нэвтрүүлгээр Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцыг буулган дахин төлөвлөн барилгажуулах ажлын талаар мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэж байгууллагын үйл ажиллагааг сурталчлав.<br>- Хот байгуулалтын үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зургийг Ebarilga веб апликейшн хосолсон нийслэлийн хот байгуулалтын цахим систем цуврал лекц-3 "Сити" их сургуульд зохион байгуулав.<br>- Улаанбаатар хотын хэт төвлөрөл, түгжрэлийн асуудлыг тодорхой хэмжээнд хот байгуулалтын чиглэлээр авах арга хэмжээний хүрээнд Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр, Энхтайваны өргөн чөлөө, 40, 50 мянгат орчимд газар доорх худалдаа, нийтийн үйлчилгээний төв гудамж байгуулах төслийн концепцийг боловсруулж байна. | |
| 2.11.9 | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Газрын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн чиглэлийн дагуу гаргаж, байгууллагын нэгж, албан хаагчдад танилцуулан, саналыг нэгтгэн 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Газрын даргаар батлуулав. (5 зорилт, 18 арга | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллана. | | | | | хэмжээ) Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн ажлын тайланг 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/01/1524 дугаартай албан бичгээр болон цахим bayarjargal.s@ulaanbaatar.mn шуудангаар тайлагнав.<br>- Авлигын эсрэг Олон Улсын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан "Авлигын эсрэг гэрэл зургийн үзэсгэлэн 2022"-д шалгарсан 10 бүтээлийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулахаар 2023 оны 2 дугаар сарын 14-ний өдрөөс сарын хугацаатай B1 давхарт байршуулав.<br>- Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбараар байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг сурталчлан холбогдох мэдээллийг байршуулав.<br>- ХАСХОМ гаргавал зохих албан тушаалын болон 2022 оны ХАСХОМ мэдүүлэх үүрэг бүхий мэдүүлэг гаргагчийн нэрсийн жагсаалтыг (71 албан хаагч) 2023 оны 01/1/14 дугаартай албан бичгээр болон munkhboldluvsandavaa@gmail.com цахим хаягаар илгээв.<br>- Шинээр албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 8 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахимаар мэдүүлж, Авлигатай тэмцэх газраар хянуулав. Ашиг сонирхлын зөрчил үүсээгүй болно.<br>- Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг 1, 2 тайлан мэдээ, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авсан (72 албан хаагч) тухай бүртгэлийн хамт цахимаар 2023 оны 01/01/410 дугаартай албан бичгээр болон munkhboldluvsandavaa@gmail.com цахим хаягаар холбогдох албан тушаалтанд хүргүүлэв. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Нийт 79 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч, баталгаажуулав.<br>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Авлигатай тэмцэх газартай хамтран “Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдэл, албан хаагчийн ёс зүйн зөрчил, авлига гарч болох нөхцөлийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар” уулзалтаар хэлэлцсэн асуудлын хүрээнд гарсан санал, дүгнэлтийг үндэслэн “ИРГЭН ТАНД” хуудсыг үйлчилгээнд нэвтрүүлсэн. “ИРГЭН ТАНД” үлдэх хуудсанд хүсэлтийг хүлээн авсан үйлчилгээний ажилтны нэр, хүлээн авсан огноо, цаг, хүсэлтийг шийдвэрлэх хугацаа, шийдвэрлэлтийн явцыг хянах боломжтой www.uda.ub.gov.mn систем, гар утасны eBarilga аппликэйшн мэдээлэл, байгууллагын үйлчилгээний мэдээлэл агуулсан цахим хуудас Авлигатай тэмцэх газрын QR код зэргийг агуулсан болно.<br>Авлигатай тэмцэх газраас гаргасан “ИРГЭН ТАНД” хуудасны талаарх шторкийг байгууллагын цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулан ил тод байдлыг нэмэгдүүлэн ажиллав.<br>https://www.facebook.com/reel/636282528542096<br>- Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Авлигаас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал”, "Авлига, ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ, түүний хор хөнөөл, урьдчилан сэргийлэх арга", "Ашиг сонирхлын зөрчил, мэдэгдэл, тайлбар гаргахад анхаарах асуудал", "Авлигын гэмт хэрэг"-ийн хуульчлагдсан байдал" сэдэвт 4 удаагийн сургалтад 48 албан хаагч хамрагдсан.<br>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авто замын салбар дахь асуудал, шийдэл, явган замын хавтан, авто замын хашлагийн төлөвлөлт, | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гүйцэтгэл, хяналт" сэдэвт хэлэлцүүлэг, "Барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг үнэлэх ба хүчитгэх, олон улсын туршлага" Олон Улсын техникийн семинар, "Барилгын салбарын ил тод байдал, Авлигаас сэргийлэх нь, олон улсын туршлага" дугуй ширээний ярилцлага, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг арилгах талаар мэдээлэл, санал солилцох уулзалт зэрэг 4 удаагийн хэлэлцүүлэг, хамтарсан дугуй ширээний уулзалтад байгууллагын удирдлага оролцсон байна. | |
| 2.11.10 | Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэр, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийн, зөвлөмж гарган, хяналт тавин ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2022 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, 2023 оны 01/01/381 дугаартай албан бичгээр хүргүүлэв. (4 зорилт, 31 арга хэмжээ 84,0%)<br>- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2022 оны хэрэгжилт - 88.5%, 2023 оны хагас жилийн хэрэгжилт 67,7% хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, tungalag.o@ulaanbaatar.mn цахим хаягаар хүргүүлэв. (5 зорилт, 9 арга хэмжээ – 88.5%)<br>- "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн 2021-2022 оны хэрэгжилт болон хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн 2022 оны жилийн эцсийн тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст 2023 оны 01/1/174 дугаар албан бичгээр,<br>- Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 1,2,3 дугаар улирлын хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж хэрэгжилтийг Хяналт шинжилгээ, үнэлгээний https://control.ulaanbaatar.mn/ цахим системээр, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - "150 мянган айл-орон сууц" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Барилга, хот байгуулалтын яаманд 2023 оны 01/1/145 дугаартай албан бичгээр хүргүүлэв. (9 арга хэмжээ - 86,7%)<br>- Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний 1, 2,3 дугаар улирлын хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, 2023 оны 01/559 дугаартай албан бичгээр хүргүүлэв. (14 зорилт, 45 арга хэмжээ – 60 %)<br>- Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2023 оны сар бүрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, 2023 оны 01/01/429 дугаартай албан бичгээр хүргүүлэв. (13 тогтоол, тэмдэглэл, 29 заалт, 92.6%)<br>- Газрын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд 2023 оны 1,2,3 дугаар улирлын байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд 2023 оны 01/01/598 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.(хэрэгжилт 100%)<br>- Албан бичгийн шийдвэрлэлтэд өдөр тутмын хяналт тавьж, судлагдаж байгаа албан бичигт 10 хоног тутам явцын тэмдэглэл хөтөлж, зөрчил гаргахгүй байхыг нийт албан хаагчдад дотоод сүлжээгээр мэдэгдэж ажиллав. 2023 оны хагас жилийн байдлаар албан бичгийн зөрчил гаргасан нийт албан хаагчдын мэдээллийг гаргаж, Захиргааны зөвлөлийн хурлаар танилцуулав. | |
| 2.11.11 | Байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн үнэлгээнд дүн шинжилгээ хийн, зөвлөмжийг хэрэгжүүлнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - 2023 оны 138 дугаар "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмж"-ийн дагуу төлөвлөгөө гаргаж, 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. (3 зорилт, 12 арга хэмжээ) | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Авлигатай тэмцэх газраас зөвшөөрөлгүй барилга, байгууламжийн талаар ирүүлсэн зөвлөмж, хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай 2022 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 03/9552 дугаар албан бичгийн дагуу хэрэгжүүлэх хариу арга хэмжээний жилийн ажлын 3 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан Газрын даргаар батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллав. Энэ ажлын хүрээнд Нийслэлийн нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй барилгын ажил гүйцэтгэж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, дүгнэлт гарган цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/288 дугаар захирамжаар байгуулагдан ажиллаж байна.<br>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 03/3070 дугаар албан бичгээр "Өргөдөл, гомдол, архив, албан хэрэг хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ирүүлсэн зөвлөмж"-ийн дагуу төлөвлөгөө гаргаж, 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. (4 зорилт, 19 арга хэмжээ)<br>Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, 2023 оны 01/01/1654 дугаартай албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд, 2023 оны 01/1649 дугаартай албан бичгээр нийслэлийн Архивын газарт тайлагнав. | |
| 2.11.12 | Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон газрын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдана. | - | Сургалтад хамрагдсан цаг /1 албан хаагч/ | 1 албан хаагчийн сургалтад хамрагдсан цаг /дунджаар 60 цаг/ | 1 албан хаагчийн сургалтад хамрагдах цаг /дунджаар 65 цагаас | Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академи, Нийслэлийн Архивын газар, "Нийслэлийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төв, Хууль, эрх зүйн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Онцгой байдлын ерөнхий | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | багагүй байх/ | газар, нийслэлийн холбогдох бусад байгууллагаас зохион байгуулсан 106 удаагийн сургалтад (цахимаар 37, танхимын 69) давхардсан тоогоор 908 албан хаагч (100 хувь) хамрагдав. | |
| 2.11.13 | “Улаанбаатар-2023” Зүүн Азийн залуучуудын наадмыг зохион байгуулахад чиг үүргийн дагуу хамтран ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | “Улаанбаатар-2023” Зүүн Азийн залуучуудын наадмыг зохион байгуулахад чиг үүргийн дагуу шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж хамтран ажилласан. | 100 |
| 2.11.14 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих ажлыг зохион байгуулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | “Тэр бум” мод үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх ажлын хүрээнд Газрын албан хаагчид Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 370 мод тарив. (2 удаа)<br>Мөн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр Айцын аманд өнгөрсөн онд тарьсан модны арчилгааг хийсэн. | 100 |
| 2.11.15 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллана. | - | Шийдвэрлэлтийн хугацаа /хоногоор/ | 9 хоног | 9 хоног | Албан хаагчдад цахим (eDoc) хэлбэрээр албан бичиг боловсруулахад гаргадаг алдаа, зөрчлийг гаргахгүй байх талаар арга зүйн зөвлөгөөг тухай бүрд нь өгч, ирсэн албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, зөрчлийг бууруулан ажиллаж байна.<br>- Нийт ирсэн бичгийн тоо - 3611<br>- Нийт явсан бичгийн тоо - 3414<br>- Шийдвэрлэлтийн дундаж хугацаа - 7 хоног<br>Шийдвэрлэлтийн хувь - 99.7% | 100 |
| 2.11.16 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллана. | - | Шийдвэрлэлт хугацаа /хоногоор/ | 10 хоног | 9 Хоног | - Газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр баталсан “Ажлын бүтээмжийг дээшлүүлэх аян”-ны удирдамжийн 3 дахь хэсэгт “Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах” гэж заасны дагуу аяны удирдамжийн хүрээнд хэрэгжилтийг хангаж, алба, хэлтсүүдэд хяналт тавин ажиллаж байна.<br>Аяны хүрээнд:<br>- Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, зөрчил тооцогдсон албан бичиг, газрын үйл ажиллагаа, хүний нөөцтэй холбоотой гарсан А, Б | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тушаалын мэдээлэл, шинээр томилогдсон болон ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн мэдээлэл, Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулах үндэслэл, нэмэлт өөрчлөлт оруулах талаар танилцуулга хийсэн.<br>- "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд анхаарах асуудал", "Албан хэрэг хөтлөлтийн eDoc систем ашиглах журам", "Зөвшөөрлийн тухай хуулийн танилцуулга", "Засгийн газар дахь хяналтын тухай хууль", "Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль", "Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-ын талаар 6 удаагийн сургалт зохион байгуулсан.<br>- 4 гомдол, 2 талархал хүлээн авсан, 2 иргэний гомдлыг татуулж, 2 иргэний гомдлыг хянан үзэж, албан хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй тул иргэнд хариу тайлбар өгч ажиллав. 2 талархлыг холбогдох нэгж, албан хаагчдад болон нийт албан хаагчдад танилцуулав.<br>- Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг Газрын хэмжээнд 2023 онд 9 хоногт оруулах зорилт тавьж ажилласнаар 2023 оны байдлаар 9 хоног, 8 цагтай байна.<br>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 11 сарын 24-ний өдрийн Чиглэл хүргүүлэх тухай бичгийн дагуу Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд 7 хоног бүр дүн шинжилгээ хийж, тайланг Пүрэв гараг бүр албан бичгээр хүргүүлж ажиллав. (3 удаа) | |
| 2.11.17 | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар баталсан "Иргэдээс Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-ыг дагаж мөрдөн ажиллаж байна.<br>- 2023 оны 12 сарын 05-ны өдрийн байдлаар 2443 өргөдөл, гомдол ирснээс: | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангaн ажиллана. | | | | | ✓ хугацаанд нь хариу өгч шийдвэрлэсэн – 2413<br>✓ шийдвэрлэх хугацаандаа судлагдаж байгаа – 28<br>Шийдвэрлэлт - 99%,<br>Шийдвэрлэлтийн дундаж хугацаа - 9 хоног.<br>- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног тутам нэгжийн албан хаагч бүрд мэдээлэл хүргүүлэн, тулгамдаж буй асуудалтай санал солилцон ажиллаж байна. Мөн нийт албан хаагчдад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн https://erp.ulaanbaatar.mn/ цахим системд зөрчилгүй, холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн ажиллах талаар сургалтуудыг зохион байгуулав. | |
| 2.11.18 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2022 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгнө. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - 2023 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2022 оны хадгаламжийн нэгжийг хуваарийн дагуу авч нийт 1768 баримтыг акт үйлдэн хүлээн авсан. Үүнд:<br>✓ Захиргаа, санхүүгийн хэлтэс – 107<br>✓ Ерөнхий архитекторын ажлын алба – 106<br>✓ Барилга, хот байгуулалтын хэлтэс- 501<br>✓ Хот төлөвлөлтийн хэлтэс-420<br>✓ Хот байгуулалтын мэдээллийн хэлтэс – 106<br>✓ Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтэс-238<br>✓ Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс – 2<br>✓ Барилга байгууламжийн чанарын хэлтэс – 23<br>✓ Хот байгуулалтын инженерийн бэлтгэл хяналтын хэлтэс- 250<br>✓ Дотоод хяналт хуулийн хэлтэс- 15<br>- Газрын даргын 2022 оны үндсэн үйл ажиллагаатай холбоотой "А" тушаал 56, хүний нөөцтэй холбоотой "Б" тушаал 155-ыг бүрэн цахимжуулж, архивлав. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Албан хэрэгцээнд 115 албан хаагчид (давхардсан тоогоор) 150 архивын баримтыг түр ашиглуулан, бүртгэл хөтлөв. | |
| ***ЗОРИЛГО 3. ДҮРМЭЭР ХҮЛЭЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:*** | | | | | | | |
| ДХЧҮХ-х Зорилт 1. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр иргэн, хуулийн этгээдэд барилга, хот байгуулалт, дахин төлөвлөлт, газар орон зайн мэдээлэл, дэд бүтэц, барилга байгууламжийн ашиглалтын аюулгүй байдлын чиглэлээр үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, ухаалаг технологийг нэвтрүүлэн шийдвэрлэнэ. | | | | | | | |
| 3.1.1 | Газраас үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн Яармаг төвд ажиллаж буй 3 албан хаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.<br>- Газраас үзүүлж байгаа нийт 8 төрлийн 36 үйлчилгээний **8917** хүсэлтийг ebarilga.mn цахим систем болон Яармаг төв, цахим системээр 1873 хүсэлтийг (www.e-mongolia.mn, www.les.ebusinessmongolia.mn, www.eservive.ulaanbaatar.mn) хүлээн авч, холбогдох хууль, журмын дагуу түргэн шуурхай, ил тод, нээлттэй хүргэж, зөвлөгөө, мэдээллийг өгч ажиллав. Үүнд:<br>✓ Шийдвэрлэсэн – 4745<br>✓ Татгалзсан – 1432<br>✓ Хянаж байгаа – 2740<br>Цахим системээр нийт **1873** хүсэлт ирснээс :<br>✓ www.e-mongolia.mn цахим хуудсаар иргэн, хуулийн этгээдээс 1163 хүсэлт ирснээс 519 хүсэлтийг шийдвэрлэж, 381 хүсэлт татгалзсан, 263 хүсэлт хянагдаж байна.<br>✓ www.les.ebusinessmongolia.mn цахим хуудсаар иргэн, хуулийн этгээдээс 382 хүсэлт ирснээс 279 хүсэлтийг шийдвэрлэж, 73 хүсэлт татгалзсан, 30 хүсэлт хянагдаж байна.<br>✓ www.eservive.ulaanbaatar.mn цахим хуудсаар 328 хүсэлт ирүүлснээс 262 хүсэлтийг шийдвэрлэж, 52 хүсэлт татгалзсан, 14 хүсэлт хянагдаж байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээлэл, мэдээллийг ашиглахад хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний мэдээлэл авах эрх, эрх чөлөөг үл хязгаарлах, төрийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх, хүн, хуулийн этгээд хуулиар хязгаарлалт тогтоогоогүй аливаа мэдээллийг саадгүй олж авах нөхцөл боломж бүрдсэн эсэхэд хяналт шалгалт хийж цахим хуудасны мэдээллийн ил тод байдлыг хангуулан ажиллав.<br>- Газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 01/10/2042 дугаартай албан бичгээр иргэн, хуулийн этгээдэд олгосон Архитектур төлөвлөлтийн 720 даалгаврыг цуцлах сонсох ажиллагааны мэдэгдлийг Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.2 дахь заалтад заасан байдлаар буюу хорин нэг буюу түүнээс дээш тооны этгээдүүдэд хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан гэснийг үндэслэн газрын веб хуудас болон мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлэл өгч ажиллан, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.2 дахь заалтад заасан бичгээр санал авах хэлбэрээр явуулж, иргэн, хуулийн этгээдээс 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломжоор хангаж мэдээллийг ил тод нээлттэй байршуулсан. | |
| 3.1.2 | Хот байгуулалтын үйл ажиллагаанд Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган захиргааны сөрөг акт гарсан тохиолдолд | - | Сөрөг актын тоо | 31 | /Сөрөг актын тоог 5 хувиар бууруулсан байна/ | - Захиргааны сөрөг акт гарах тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлд заасны дагуу эрх ашиг нь хөндөгдөж буй давхардсан тоогоор 30 иргэн, хуулийн этгээдэд захиргааны сонсох ажиллагаа явуулсан. Үүнд:<br>✓ Архитектур төлөвлөлтийн даалгавар 10, Загвар зураг 6, Барилгын ажлын | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүртгэлжүүлж мэдээлж ажиллана. | | | | | зөвшөөрлийн 2 гэрчилгээ хүчингүй болгож,<br>✓ Барилгын ажлын зөвшөөрлийн 5 гэрчилгээг түдгэлзүүлсэн.<br>✓ Сонсох ажиллагааны 30 хариу тайлбарыг үндэслэн 3 захиргааны актыг хэвээр үлдээсэн.<br>- Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас 2023 онд газрын эрх хүчингүй болсон 101 байршлын жагсаалтыг 2023 оны 01-09/4121 дугаартай албан бичгээр ирүүлсний дагуу газрын даргын Захиргааны актыг хүчингүй болгох тухай 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/28 дугаар тушаалаар иргэн, хуулийн этгээдийн 31 Архитектур төлөвлөлтийн даалгавар, Загвар зургийг хүчингүй болгож шийдвэрлэв.<br>- Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/866 дугаартай захирамжаар 2016 оноос өмнө иргэн, хуулийн этгээдэд батлан олгосон Архитектур төлөвлөлтийн даалгаврыг хүчингүй болгохыг үүрэг болгосны дагуу 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 01/10/2042 дугаартай албан бичгээр 720 иргэн, хуулийн этгээдэд сонсох ажиллагаа явуулж, 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар Архитектур төлөвлөлтийн 711 даалгаврыг цуцалсан. | |
| 3.1.3 | eBarilga.ub.gov.mn нэгдсэн системд мэдээллийг оруулах, баяжилтыг тогтмол хийнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100 | eBarilga.ub.gov.mn нэгдсэн систем нэвтэрснээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>- 1436 хаяг дугаар хүссэн өргөдлөөс 61 зөрчилтэй хүсэлтийг буцааж, 1497 өргөдлийн 1756 барилгын мэдээллийг геопорталын баригдсан барилга давхаргад шивж оруулан, хаягийн тодорхойлолтоор хариу олгосон.<br>- 388 тэг тэнхлэгийн актыг мэдээллийн санд бүртгүүлэх хүсэлт ирснээс 732 өргөдлийн барилгын мэдээллийг тэг тэнхлэгийн давхаргад оруулан, мэдээллийн санд хүлээж авсан актаар хариу олгосон. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-аас холбооны АТС-ийн мэдээллийг авч дэд мэдээллийн сангийн өгөгдлийг шинэчилж давхарга хэсэгт оруулав.<br>- Авто зам, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасын давхаргын мэдээллийг шинэчлэх ажлыг хийж байна.<br>- Нийслэлийн Хот байгуулалтын мэдээллийн сан дахь нийслэлийн нутаг дэвсгэрийн нийтийн мэдээлэл болон барилга байгууламжийн мэдээллийг илэрхийлэх тэмдэгтийг 6736:2018, 6702:2018 стандартын дагуу QGIS программ дээр шинэчилж оруулсан.<br>- Албаны хэрэгцээнд eBarilga цахим системийн баригдсан, төлөвлөгдсөн барилга, байгууламж, авто зам, зөвшилцсөн инженерийн шугам сүлжээний мэдээллийн өгөгдлийн баазыг газар зүйн мэдээллийн системийн Qgis платформд холбон бусад суурь давхаргыг үүсгэн албан хаагчдын хэрэглээнд нэвтрүүлсэн. | |
| 3.1.4 | Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулан ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Газрын даргын 2023 оны А/08 дугаар тушаалаар Хэрэглэгчийн үнэлгээ хийх, судалгааны ажлын хэсэг байгуулагдан, 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>- Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангах зорилтын хүрээнд Нийслэлээс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаанд иргэдийн санал, шүүмжлэлийг тусгаж, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор үйлчилгээ авч буй иргэн, хуулийн этгээдээс авч буй цахим санал асуулга, мөн газраас үзүүлж буй үйлчилгээний тоон мэдээ болон иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны мэдээг 7 хоног бүрийн Пүрэв гарагт Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нийт 31 удаа udval.b@ulaanbaatar.mn цахим хаягт хүргүүлэв. Тайлангийн хугацаанд | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийт 4614 иргэн, хуулийн этгээдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан байна. | |
| 3.1.5 | Төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Орон сууц болон олон нийтийн зориулалттай барилга байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд дүгнэлт гаргах, паспортжуулах ажлын тендерийн урилгыг байгууллагын uda.ub.gov.mn цахим хуудсанд байршуулсан. | 100 |
| 3.1.6 | Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Төрийн үйлчилгээний нэгдсэн портал e-Mongolia-р дамжин ирүүлдэг тус газрын хүсэлтүүдийг eBarilga хот байгуулалтын цахим системд холбох талаар e-mongolia академи УТҮГ-т албан бичиг хүргүүлж, 1 дүгээр сарын 23-ны өдөр холбогдох албан хаагчидтай хамтарсан уулзалт хийж, санал солилцов.<br>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Цахим хөгжил, мэдээлэл технологийн газар хамтран хэрэгжүүлж буй "Онлайн бизнес төв"-д холбох тус газрын үйлчилгээний хүсэлт, шийдвэрлэлтийг eBarilga хот байгуулалтын цахим системд хэрхэн холбох талаар Цахим хөгжил, мэдээлэл технологийн газар болон систем хөгжүүлэгч Ухаалаг шийдэл ХХК, Смарт дата ХХК-ийн холбогдох албан хаагчидтай хамтарсан цахим уулзалтыг зохион байгуулав. Уулзалтын дагуу eBarilga хот байгуулалтын цахим системийг хөгжүүлэгч компани шаардлагатай өгөгдөл мэдээллийг Ухаалаг шийдэл ХХК-д хүргүүлэв.<br>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Авлигатай тэмцэх газартай хамтран "Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдэл, албан хаагчийн ёс зүйн зөрчил, авлига гарч болох нөхцөлийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар" уулзалтаар хэлэлцсэн асуудлын хүрээнд гарсан санал, дүгнэлтийг үндэслэн "ИРГЭН | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ТАНД" хуудсыг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс үйлчилгээнд нэвтрүүлж эхэлсэн.<br>- "ИРГЭН ТАНД" үлдэх хуудас нь хүсэлтийг хүлээн авсан үйлчилгээний ажилтны нэр, хүлээн авсан огноо, цаг, хүсэлтийг шийдвэрлэх хугацаа, шийдвэрлэлтийн явцыг хянах боломжтой https://ebarilga.ub.gov.mn систем, гар утасны eBarilga аппликэйшн мэдээлэл, байгууллагын үйлчилгээний мэдээлэл агуулсан цахим хуудас, Авлигатай тэмцэх газрын QR код зэргийг агуулсан болно.<br>- Барилга байгууламжийг мэдээллийн санд бүртгүүлэх, хаяг дугаар хүсэх, Байр зүйн зургийг мэдээллийн санд бүртгүүлэх, Инженерийн шугам сүлжээний зурган мэдээллээр үйлчлэх, Тэг тэнхлэгийн актыг бүртгүүлэх үйлчилгээнүүдийг emongolia.mn, ebariiga.ub.gov.mn, les-e-business.mn геопорталуудаар иргэн, хуулийн этгээдээс цахимаар хүлээн авч, түргэн шуурхай шийдвэрлэн ажиллав. | |
| 3.1.7 | Олон Улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100 | - Газрын даргын 2023 оны А/01 дүгээр тушаалаар "Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандарт" нэвтрүүлэх дэд ажлын хэсгийг байгуулсан.<br>- Газрын даргын 2023 оны А/09 дүгээр тушаалаар "Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх хамрах хүрээ, ажлын төлөвлөгөөг батлуулав. (4 зорилт, 26 арга хэмжээ)<br>- Стандарт нэвтрүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөний дагуу байгууллагын зөрүүгийн шинжилгээ, орчны шинжилгээ, сонирхогч талыг тодорхойлох, үйл явцыг тодорхойлох шинжилгээ хийх зэрэг 11 удаагийн сургалт, практик ажиллагаанд хуваарийн дагуу нийт албан хаагчид болон ажлын хэсгийн гишүүд хамрагдсан.<br>- Монголын менежментийн зөвлөхүүдийн холбоо ТББ-аас 2022 оны 12 дугаар сарын 01-ний | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрүүдэд зөвлөх үйлчилгээг авч ажилласан. Зөвлөх үйлчилгээний ажлыг дүгнүүлэхээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны 01/01/3364 дугаар албан бичгээр хүсэлт хүргүүлсэн. | |

3 зорилго, 28 зорилт, 142 арга хэмжээ, хэрэгжилтийн дундаж 94.3 хувь. Үүнээс:

100%-ийн хэрэгжилттэй 120 арга хэмжээ,
90%-ийн хэрэгжилттэй 8 арга хэмжээ,
70%-ийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ,
30%-ийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ,
0%-ийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ.

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ч.БАДАМХАНД

НЭГТГЭСЭН: БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Л.ЭНХТУУЛ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: МЭРГЭЖИЛТЭН Л.АДЪЯАСҮРЭН

# ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА

2023 оны 12 дугаар сарын 11 Улаанбаатар хот

Газрын 2023 оны гүйцэтгэлийн тайлан (*Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт*)-д Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2, 6.3-ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийв.

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2023 онд нийт 3 зорилго, 28 зорилтын хүрээнд 142 арга хэмжээ туссанаас хагас жилийн байдлаар 74.6 хувьтай байсан бол жилийн эцсийн байдлаар 94.3 хувийн хэрэгжилттэй буюу 19.7 хувиар өссөн үзүүлэлттэй үнэлэгдсэн.

*2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээ:*

| № | Зорилго | Зорилтын тоо | Арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Орон зайн оновчтой төлөвлөлт | 16 | 60 | 89.0% |
| 2 | Хуулиар хүлээх чиг үүрэг | 11 | 75 | 98.0% |
| 3 | Дүрмээр хүлээх чиг үүрэг | 1 | 7 | 100.0% |
| Нийт | | 28 | 142 | 94.3% |

*Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 142 ажил, арга хэмжээний хэрэгжилтийн хувь:*




Үүнээс бүрэн хэрэгжсэн 142 арга хэмжээ, хэрэгжих шатандаа байгаа 15 арга хэмжээ, хэрэгжилт хангалтгүй 7 арга хэмжээ үнэлэгдсэн. Үүнээс:

1. “Монгол Улсын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” батлагдахаас шалтгаалан хэрэгжилт удааширсан 2 арга хэмжээ;

- *1.1.2. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулна.*

- *1.1.3. Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийг боловсруулна.*

2. Хэрэгжилт хангалтгүй буюу хөрөнгө шийдвэрлэгдээгүйн улмаас хэрэгжээгүй 5 арга хэмжээ байгаа бөгөөд Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгуулах саналыг 2023 оны 01/01/751 дугаартай албан бичгээр, Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2023 оны 01/01/1324 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн. Мөн Улс, нийслэлийн 2024 оны төсвийн төсөлд тусгуулах санал хүргүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Үүнд:

- *1.1.6. Гэр хорооллыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулна.*
- *1.6.2. Барилга байгууламжийг паспортжуулан газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийж, лаборатори байгуулах ажлын хүрээнд Техникийн хяналтын байгууллагын MNS ISO/IEC 17020:2013 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.*
- *1.6.3.1. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, олон нийтийн барилгын хүчитгэлийн зураг, стандартын шаардлага хангасан амины сууцны нэг маягийн загвар зураг боловсруулна.* (Захирамжийн тоо)
- *1.7.1. Улаанбаатар хотын дагуул, хаяа хот, тосгодын төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.*
- *1.7.2. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр аж ахуй нэгжийг хотоос шилжүүлэх нэгдсэн бодлого боловсруулна.*

**Санал, зөвлөмж:**

2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан /гүйцэтгэлийн төлөвлөгөө/-гийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дараах зөвлөмжийг алба, хэлтсүүдэд өгч байна. Үүнд:

1. Алба, хэлтсүүд жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө болон Нийслэлийн 2020-2024 оны Стратеги төлөвлөгөөтэй нягт уялдуулж төлөвлөх, шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо анхаарах;
2. Тайланг бодитой, товч тодорхой, нэг ажил, арга хэмжээний гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтаах, тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх, хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцөлийг заавал тодорхой дурдах гэсэн тусгай шаардлагуудыг заавал хангаж байх,
3. Алба, хэлтсүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт хөрөнгө шийдвэрлэгдээгүйн улмаас удаашралтай, хэрэгжих нөхцөл бүрдээгүй 5 арга хэмжээг Улс, нийслэлийн 2024 оны төсвийн төсөлд тусгуулах ажлыг зохион байгуулах,
4. Газрын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэж, мэдээллийн ил тод байдлыг хангаж, цахим http://uda.ub.gov.mn/ веб хуудсанд мэдээ, мэдээллийг цаг тухай бүрд нь шинэчлэн байршуулах.

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ч.БАДАМХАНД

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: МЭРГЭЖИЛТЭН Л.АДЪЯАСҮРЭН